



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2016.03.31 № 571

таний _____ -ны № _____ -т

УЛСЫН ИХ ХУРЛЫН ТӨСВИЙН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА
Ч.УЛААН ТАНАА

Үндэсний аудитын газрын 2015 оны үйл
ажиллагааны тайланг хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



\\\10.10.10.20\Bichig_Khereg\Yawsan_Bichig\2016\0331TG3.Docx

073060



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН 2015 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН



Улаанбаатар хот
2016 он



ӨМНӨХ ҮГ



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайланг Танд өргөн барьж байна.

Төрийн аудитын байгууллагын хувьд 2015 он аудитын үйл ажиллагааны болон тогтолцооны шинэчлэлийг гүнзгийрүүлж, аудитын чанар үр дүнг дээшлүүлэх зорилт дэвшиүүлсэн, төрийн санхүүгийн хяналтыг хуулийн дагуу хөндлөнгийн хараат бус хяналтын байгууллага хэрэгжүүлж эхэлсний 20 жилийн ой тохиосон онцлог жил боллоо.

Төрийн аудитын байгууллага 2015 онд Төсвийн тухай хууль, УИХ болон Төсвийн Байнгын хорооны тогтоолоор тусгайлан баталсан аудитуудыг гүйцэтгэхэд санхүү, хүн хүч, цаг хугацааны нөөцийг бүрэн төвлөрүүлж ажиллалаа.

Хууль, УИХ-ын шийдвэрээр заасан хугацааны цагалбартай жил бүр хийдэг Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн, Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн, Улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын, Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зэрэг томоохон аудитуудыг зохих хугацаанд нь гүйцэтгэж УИХ-д тайлагналаа.

Түүнчлэн УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор баталсан сэдвүүдээр нэгдсэн удирдамжийн дагуу аудит хийж, хэд хэдэн аудитын тайланг тус Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж, гаргасан тодорхой шийдвэрүүдэд хяналт тавьж ажилласан нь төрийн аудитын шинэчлэлийн бодлогыг гүнзгийрүүлэх, парламентын хяналтын соёлыг төлөвшүүлэхэд чухал алхам болсон гэж үзэж байна.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хөндлөнгийн хяналт тавих үүргийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд уг хуулийн хэрэгжилтэд 2 удаа аудит хийж, хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зөвлөмжийг Засгийн газарт хүргүүлж ажиллав.

Аудитын дээд байгууллагуудын холбооноос баталсан аудитын олон улсын стандартыг монгол хэлээр анх удаа хэвлүүлж, төрийн аудитын ажилтнуудын хүртээл болгож эхэлсэн нь аудитын технологи, арга зүйн шинэчлэлийн томоохон арга хэмжээ боллоо.

Санхүүгийн тайлангийн аудитын СТАУС программ хангамж, Улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн аудитын өгөгдлүүдийг цуглуулах Check list системийг нэвтрүүлснээр аудитын үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах бодлого бодитойгоор хэрэгжиж эхэллээ.

Аудитын арга зүйг шинэчлэх, байгууллагын чадавхийг бэхжүүлэх, хүний нөөцийн мэдлэг, үр чадвар, хариуцлагыг сайжруулах замаар аудитын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилт бодитой үр дүнд хүрч эхэлсэн нь тайлант жилийн онцлогийг тодорхойлж байна.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

А.ЗАНГАД



Товчилсон үгсийн жагсаалт

АЙ ДИ АЙ /IDI/	ИНТОСАИ-н Хөгжлийн санаачилга
ИБУИНВУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улс
ИНТОСАИ /INTOSAI/	Аудитын дээд байгууллагуудын олон улсын байгууллага
ИССАИ /ISSAI/	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
УИХ	Улсын Их Хурал
БНСВУ	Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улс
АСОСАИ	Азийн аудитын дээд байгууллагуудын нийгэмлэг
СТАУС	Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын систем
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХК	Хувьцаат компани
ТӨХК	Төрийн өмчийт хувьцаат компани
ДЦС-2	Дулааны цахилгаан станц-2
ОХУ	Оросын Холбооны Улс
НҮБ	Нэгдсэн Үндэсний байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АДБОУН	Аудитын дээд байгууллагын олон улсын нийгэмлэг
НББГ	Нягтлан бодох бүртгэлийн газар
ОУБ	Олон улсын байгууллага
АТГ	Авлигатай тэмцэх газар
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЗГСНТ	Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан
ТЕЗСТ	Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
АНАГ	Аймаг, нийслэлийн аудитын газар
ХАК	Хувийн аудитын компани
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗГТС	Засгийн газрын тусгай сан
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
БОНХАЖЯ	Байгаль орчин ногоон хөгжил, аялал жуучлалын яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
УУЯ	Уул уурхайн яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
МУИС	Монгол Улсын их сургууль
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
АШУУИС	Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль
МУБИС	Монгол Улсын боловсролын их сургууль
ШУТИС	Шинжлэх ухаан технологийн их сургууль
СУИС	Соёл урлагийн их сургууль
ХСИС	Хууль сахиулах их сургууль
БХИС	Батлан хамгаалах их сургууль
ХНН	Хувь нийлуулсэн нийгэмлэг
БСШУЯ	Боловсрол соёл шинжлэх ухааны яам



Нэг. Ерөнхий зүйл

Тайлант он Аудитын дээд байгууллагуудын холбооноос баталсан аудитын олон улсын стандартыг монгол хэлээр анх удаа хэвлүүлэн нэвтрүүлж эхэлсэн, төрийн аудитын байгууллагыг холбосон нэгдсэн VPN сүлжээг ашиглан онлайн сургалт, семинар, ярилцлагыг анх удаа зохион байгуулсан, төрийн аудитын ажилтнуудын мэргэшлийн түвшинг тогтоо шалгалтыг авсан зэрэг төрийн аудитын арга зүй, төрийн аудитын байгууллагын чадавхийг бэхжүүлсэн, хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага байгуулагдсаны 20 жилийн ажлын үр дүнг дүгнэсэн онцлог жил байлаа.

Төрийн аудитын байгууллагын 2015 оны үндсэн үйл ажиллагааг хугацаагаар тоймлон харуулбал:

Нэгдүгээр сард:

1. Төрийн аудитын байгууллагаас 2015 онд нийлүүлэх аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг баталж, аудит бүрт шаардагдах нөөцийг хуваарилж, төрөлжсөн болон орон нутгийн аудитын байгууллагуудыг нэгдсэн удирдамжаар хангаж, аудитыг гүйцэтгэх бэлтгэл ажлыг хангав.
2. Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар "Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах" мэргэшлийн шалгалтын журам", "Аймаг, нийслэлийн аудитын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлж дүгнэх журам", "Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад дурдсан байнга хадгалах хадгаламжийн нэгжүүдийн цахим хувь үйлдэх ажлын удирдамж"-ийг батлав.
3. Өмнөх оноос шилжсэн 5 бие даасан аудитын тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, "Эрчим хүчний салбарын төрийн өмчтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн"-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг батлав.

Хоёрдугаар сард:

1. Төрийн аудитын байгууллагын 2014 оны үйл ажиллагааны тайланг УИХ-ын гишүүдэд цахим болон хэвлэмэл хэлбэрээр тайлагнав.
2. Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулж, үнэлгээний тайланг бэлтгэж хэвлүүлэв.
3. Концессион хуулийн хэрэгжилт, Төрийн мөнгөний бодлогын хэрэгжилт, үр дүн, Авто замын хөрөнгө оруулалт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг батлав.
4. Төсвийн тухай хуулийн дагуу 184 Төсвийн шууд захирагчийн 2014 санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын гэрчилгээг холбогдох захирагч нарт гардуулав.



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

- Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Үндсэн чиглэл, Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаанд хийх гүйцэтгэл, нийцлийн аудитын төлөвлөлтийн ажил бүрэн хэрэгжиж, аудитын талбарын үе шатны ажил хэрэгжиж эхэлсэн.

Гуравдугаар сард:

- Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүнд хийсэн аудитын тайланг батлав.
- Хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн оид зориулсан “Төрийн аудитын байгууллагын 20 жилийн хөгжил, туршлага цаашид сайжруулах асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурал, хэлэлцүүлгийг зохион байгуулав.
- Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг хэвлүүлж, төрийн аудитын ажилтнуудад түгээв.
- Төсвийн тухай хуулийн дагуу 45 Төсвийн төвлөрүүлэн захирагч, Засгийн газрын тусгай сан болон 80 Төрийн өмчтэй аж ахуйн нэгжийн 2014 санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын гэрчилгээг холбогдох захирагч нарт гардуулав.
- Монгол Улсын Үндэсний аудитын газар, ОХУ-ын Тооцооны танхимын Удирдлагын зөвлөлийн нэгдсэн хуралдаанаар хамтран гүйцэтгэсэн аудитын тайланг хэлэлцэж, баталгаажуулан холбогдох байгууллагуудад зөвлөмж хүргүүлэв.
- Үндэсний аудитын газрын ажилтнуудын ажиллах орчинг сайжруулах, өрөөний багтаамжийг нэмэгдүүлэх зорилгоор ажилтнуудын ажлын байрны зохион байгуулалт, өрөөний загварыг өөрчлөн тохижуулсан.

Дөрөвдүгээр сард:

- Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн аймгуудын нэгдсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилт, Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, төрөөс газар тариалангийн салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийн үйл ажиллагаа, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангуудыг батлав.
- ОХУ-ын Москва хотын Тооцооны төвийн үйл ажиллагаатай танилцаж, сургалт семинар зохион байгуулав.
- Төрийн аудитын байгууллагад мөрдөх "Мэдээллийн аюулгүй байдлыг хангах журам", "Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чиглэлийн үйл ажиллагааг зохицуулах журам", "Компьютер техник, тооног төхөөрөмж болон дотоод сүлжээ, цахим шуудан ашиглалтын журам", "Төрийн аудитын байгууллагын Ёс зүйн зөвлөлийн ажиллах журам"-ыг тус тус батлав.



4. Төсвийн тухай хуулийн дагуу 56 Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2014 санхүүгийн тайланг баталгаажуулж, аудитын гэрчилгээг холбогдох захирагч наарт хүргүүлэв.

Тавдугаар сард:

1. Төрийн аудитын байгууллагаас 2015 оны сүүлийн хагас жилд гүйцэтгэх нийцлийн болон гүйцэтгэлийн аудитуудын төлөвлөлтийн үе шатанд хийх судалгаа, нөхцөл байдлын шинжилгээний ажил эхэлсэн.
2. Монгол Улсын Төрийн аудитын байгууллага, ОХУ-ын Тооцооны танхимтай хамтран хил орчмын байгаль орчны талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдалд хийх зэрэгцээ аудитын төлөвлөгөө батлагдаж, хоёр орны хил залгаа аймаг, мужийн аудитын баг гүйцэтгэлийн ажлаа эхэлсэн.
3. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл болон Засгийн газрын санхүүгийн тайланг баталгаажуулах аудитаар улс орон нутгийн түвшинд илрүүлсэн асуудлуудыг судалж, аудитын нэгтгэсэн тайлан боловсрууллаа.
4. Төрийн аудитын байгууллага нэгдсэн VPN сүлжээг ашиглан сургалт, ярилцлага, семинарыг онлайнаар анх удаа зохион байгуулж, анхны ярилцлагыг Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, түүнд тавих хяналтын үүргийг төрийн аудитын байгууллага хэрхэн хангаж ажиллах талаар хэлэлцэв.

Зургадугаар сард:

1. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Улс, орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүн, Засгийн газрын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан "Ажилтай орлоготой Монгол хүн", "Эрүүл чийрэг Монгол хүн" төслийн хэрэгжилт, үр дүн", МҮОНРТ-ийн 2012-2014 онд улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалт, Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитын тайлангуудыг батлав.
2. Хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг зохион байгуулахтай холбогдуулан төрийн аудитын шилдэг бүтээл шалгаруулах журмыг батлав.
3. Монгол хэлнээ орчуулж, хэвлэсэн аудитын олон улсын стандартыг хүлээн авах арга хэмжээг УИХ-ын Төсвийн байнгын хороо, УИХ-ын Тамгын газартай хамтран зохион байгуулав.
4. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, үйл явцад 2015 оны эхний хагас жилийн байдлаар аудит хийж, зөвлөмж, тайланг баталгаажуулан холбогдох байгууллагуудад хүргүүлж, нийтийн сонсгол, хэлэлцүүлэгт оролцов.



Долоодугаар сард:

1. Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.4.7, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дугаар заалтыг үндэслэн төрийн аудитын ажилтнуудад аудитын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журмыг боловсруулж, Ерөнхий аудиторын тушаалаар батлан хэрэгжүүлэв.
2. Төрийн аудитын байгууллагын 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны статистик мэдээг нэгтгэн боловсруулж, тайлагнан Үндэсний аудитын газрын Үр дүнгийн хурлаар хэлэлцүүлэв.
3. Өмнөх онд гүйцэтгэсэн аудитын мөрөөр хийх үйл явцыг хэрэгжүүлж тайлангаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн үр дүнг бүртгэх, хэрхэн хэрэгжиж байгаад хяналт тавьж, хэрэгжүүлэх боломжийг нэмэгдүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг зохион байгууллаа.

Наймдугаар сард:

1. Төрийн аудитын байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, нийгмийн хамгааллын хөтөлбөрийг батлав.
2. "Хөндлөнгийн хараат бус төрийн хяналт-20" сэдэвт шилдэг өгүүлэл, илтгэл шалгаруулах уралдаанд ирсэн бүтээлийг өжлийн хэсэг томилон дүгнэв.
3. УИХ-ын Төсвийн байнгын хорооны тогтоолд тусгагдсан хугацаатай аудитуудын гүйцэтгэлийн үе шатны ажлуудыг хэрэгжүүлж ажиллав.
4. Төрийн аудитын байгууллагын 2016 онд гүйцэтгэх аудитын сэдвийг тодорхойлох урьдчилсан судалгаа хийх, боломжит эрсдэлүүдийг судлах төлөвлөлтийн дүн шинжилгээний ажилбаруудыг хэрэгжүүлэв.

Есдүгээр сард:

1. УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газарт өгсөн үүрэг, даалгавруудын хэрэгжилтэд хийсэн аудитын тайланг батлав.
2. Монгол Улсын 2016 оны нэгдсэн төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх, зардал хэмнэх, хууль тогтоомжид өөрчлөлт оруулах саналын төслийг боловсруулж УИХ-д өргөн барив.
3. Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.4 дүгээр заалтыг үндэслэн төрийн байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах журмыг батлав.
4. Санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитын арга зүйг төрийн аудитын бүх ажилтнуудад эзэмшүүлэх, нэвтрүүлэх сургалтыг бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулав.



Аравдугаар сард:

1. 2016 онд Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулийн дагуу төрийн аудитын байгууллагаас санхүүгийн аudit хийх Төсвийн ерөнхийлөн захирагчид, төсөл, сан, түүвэрт хамруулах байгууллагууд, 2015 оны санхүүгийн тайландаа итгэл үзүүлэх байгууллагуудыг батлав.
2. Санхүүгийн аудитын тайланд хийсэн чанарын баталгаажуулалтын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлав.
3. АДБОУН-ээс баталсан Олборлох аж үйлдвэрийн аudit, Гүйцэтгэлийн аудитын чанарын баталгаажуулалтын гарын авлага, удирдамжийг монгол хэлнээ орчуулж, хэвлэн тараав.

Арван нэгдүгээр сард:

1. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт, үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг батлав.
2. Өмнөговь, Дундговь, Төв, Дорноговь, Говьсүмбэр аймгийн Аудитын газруудын болон Үндэсний аудитын газрын ажилтнуудад төрийн аудитын олон улсын стандартыг эзэмшиүүлэх сургалтыг зохион байгуулав.
3. Он дамжин хэрэгжих гүйцэтгэл болоён нийцлийн аудитын тайлагналын үе шатны ажилбаруудыг хэрэгжүүлэв.

Арван хоёрдугаар сард:

1. Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын журмын дагуу Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар томилогдсон Ажлын хэсэг төрийн аудитын байгууллагуудын ажилтнуудаас мэргэшлийн шалгалт авч, дүнг Үндэсний аудитын газрын Удирдах зөвлөлөөр хэлэлцүүлэв.
2. Төрийн аудитын байгууллагын нэгдсэн сүлжээний орчинд ажиллах, мэдээллийн аюулгүй байдлын тухай сэдэвт сургалтыг зохион байгуулав.
3. Гүйцэтгэл, нийцлийн болон аймгуудын аудитын газруудын аудитын үйл ажиллагаанд хийсэн чанарын баталгаажуулалтын хяналтын тайланг батлав.
4. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн нийцлийн аудитын тайланг батлав.

Төрийн аудитын байгууллагын 2015 оны үндсэн үйл ажиллагаа, түүний үр дүнг тоон үзүүлэлтээр харуулвал:

Төрийн аудитын байгууллага 2015 онд гүйцэтгэлийн 64, санхүүгийн тайлангийн 4093, нийцлийн 15, нийтдээ 4172 аudit хийжээ.



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

- Төрийн аудитын байгууллагын санхүүжилтийн нэг төгрөгт 56.66 төгрөгийн үр өгөөж ногдож байна.
- Төрийн аудитын ажилтнууд 22.9 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 17.1 тэрбум төгрөгийг 2015 онд нь багтаан төсөвт төвлөрүүлсэн бөгөөд нийтдээ 30.0 тэрбум төгрөгийн орлогыг улс, орон нутгийн төсөвт оруулжээ.
- 2015 онд зөрчил гаргасан 732 албан тушаалтанд хариуцлага тооцуулж, 89 албан тушаалтны асуудлыг хууль хяналтын байгууллагад шилжүүлжээ.

Санхүүгийн тайлангийн аудитын талаар: 2015 онд төрийн аудитын байгууллага Төсвийн тухай хуульд заасан цаглабарын дагуу 2014 оны Засгийн газрын, улсын болон орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагч, шууд захирагч, төсөл, хөтөлбөр, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын 4093 санхүүгийн тайланд аудит хийж, энэ аудитад нийтдээ 48.0 мянган хүн-өдөр зарцуулж, аудитын өртөг нь 4.6 тэрбум төгрөг болсон байна.

Аудитаар 9.6 тэрбум төгрөгийн үр өгөөжийг хүлээн зөвшөөрсөн нь зардлын нэг төгрөгт 2.1 төгрөгийн үр өгөөж ногдож байгаа бөгөөд 8.1 их наяд төгрөгийн зөрчлийг залруулсан байна. Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдсан байгууллагын 85.3 хувь нь зөрчилгүй, 12.9 хувь нь хязгаарлалттай, 0.9 хувь нь сөрөг санал дүгнэлт авсан бөгөөд 0.8 хувь буюу 30 байгууллагын санхүүгийн тайланд дүгнэлт өгөхөөс татгалзсан байна.

Гүйцэтгэлийн аудитын талаар: 2015 онд төрийн аудитын байгууллага Монгол Улсын хууль, УИХ-ын шийдвэрээр 4, УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор 9, аймаг, нийслэлийн ИТХ-ын хүсэлтээр 51, нийтдээ 64 гүйцэтгэлийн аудит хийж, энэ аудитад нийтдээ 21.1 мянган хүн-өдөр зарцуулж, аудитын өртөг нь 2.0 тэрбум төгрөг болсон байна.

Аудитаар 513.6 тэрбум төгрөгийн үр өгөөжийг зөвшөөрүүлж, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах, албан тушаалтанд хариуцлага тооцох 1010 зөвлөмж, 215.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага өгч, төлбөрийн актаар улс, орон нутгийн төсөвт 8.2 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна.

Нийцлийн аудитын талаар: 2015 онд төрийн аудитын байгууллага УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор 10, аймаг, нийслэлийн ИТХ-ын хүсэлтээр 1, УИХ-ын өгсөн үүрэг даалгаврын дагуу 4, нийтдээ 15 аудит хийж, энэ аудитад нийтдээ 10.2 мянган хүн-өдөр зарцуулж, аудитын өртөг 981.5 сая төгрөг болсон байна.

2015 онд төрийн аудитын байгууллага нийцлийн аудитаар 7.0 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, үүний 5.5 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт оруулж, зөрчил арилгах 424.7 тэрбум төгрөгийн албан шаардлага, 817 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд өгч ажиллав.



**Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны
үр дүнгийн зарим үзүүлэлтүүд**

N:	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2012 он	2013 он	2014 он	2015 он
1	1 төгрөгт ногдох үр өгөөж	төгрөг	44.80	55.20	92.16	56.66
2	Улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн орлого	тэрбум төгрөг	32.50	24.80	14.04	30.0
3	Тогтоосон төлбөрийн акт	тоон дүн	тоо	2032	2355	2035
		мөнгөн дүн	тэрбум төгрөг	70.50	35.14	18.60
		Үүнээс: хэрэгжсэн	тэрбум төгрөг	23.92	23.10	13.70
4	Өгсөн албан шаардлага	тоон дүн	тоо	1760	2223	3195
		хэрэгжсэн	тоо	1572	1892	2654
5	Илрүүлсэн алдаа зөрчил	тоон дүн	тоо	10368	22827	18504
		хэрэгжсэн	тэрбум төгрөг	3902.6	7147.5	12857.5
6	Албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал	тоон дүн	тоо	610	682	857
		хэрэгжсэн	тоо	474	607	767
7	Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		тоо	65	102	65
						89

* 2003-2015 оны ажлын үр дүнгийн дэлгэрэнгүй үзүүлэлтийг Хавсралт №1-ээс үзнэ үү

**Хоёр. Төрийн аудитын үйл ажиллагааны
үр дүнгийн талаар**

2.1. Үйл ажиллагааны төлөвлөгөө:

2.1.1. Төрийн аудитын тухай хуульд орсон өөрчлөлтийн дагуу Төсвийн Байнгын хорооноос Төрийн аудитын байгууллагын гүйцэтгэх аудитын сэдвийг 2 дахь жилдээ батлаж хүргүүлэв. УИХ-ын Төсвийн Байнгын Хорооны 22 аудитыг гүйцэтгэсгээд 20 дугаар тогтоолыг үндэслэн Төрийн аудитын байгууллагын 2015 оны аудитын болон ажил үйлчилгээний төлөвлөгөөг боловсруулж баталлаа.

2.1.2. Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 95 дугаар тушаалаар Хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсэг, төлөвлөгөө, нэгдсэн арга хэмжээний хөтөлбөрийг батлав.

2.2. Төрийн аудитын стандарт, арга зүй:



2.2.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар монгол хэлнээс орчуулж, хэвлэсэн аудитын олон улсын стандартыг хүлээн авах арга хэмжээг УИХ-ын Төсвийн Байнгын хороо, УИХ-ын Тамгын газартай хамтран орчуулагч, редактор, хэвлэсэн компанийн төлөөлөгч нарыг оролцуулан Төрийн ордны Фойе танхимд зохион байгуулав. Уг стандарт нь аудитын 86 стандартыг багтаасан 11 боть номоос бүрдсэн бөгөөд нийтдээ 3550 ном хэвлүүлж, уг стандартыг төрийн аудитын ажилтнууд үйл ажиллагаандaa ашиглах боломжийг хангалаа.

2.2.2. Монгол улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг хэвлүүлж, төрийн аудитын байгууллагын ажилтнуудын хүртээл болголоо.



2.2.3. Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Гүйцэтгэлийн аудитын, Нийцлийн аудитын, Төлбөрийн акт тогтоох, албан шаардлага өгөх, Чанарын хяналтын, Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны статистик мэдээг гаргах маягт, тайлан бичих журмуудын төслийг аудитын арга зүйн өнөөгийн байдлын харьцуулсан судалгаанд үндэслэн боловсруулж байна.

2.3. Аудитын арга зүйг эзэмшүүлэх сургалт:

2.3.1. Монгол Улсын Ерөнхий аудиторт төрийн аудитын байгууллагын ажилтнуудын 2015 оны сургалтын төлөвлөгөөг боловсруулан танилцуулж, батлуулан төлөвлөгөөнд туссан ажлуудын хэрэгжилтийг хангаж ажилласан.

2.3.2. Аудитын олон улсын стандартыг эзэмшүүлэх, сургах, нягтлан бодох бүртгэлийн болон санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, СТАУС програмыг нэвтрүүлэх, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг ашиглах сэдвүүдээр нийтдээ 45 сургалтыг онлайн болон танхимын хэлбэрээр зохион байгуулж, сургалтад нийтдээ 712¹ ажилтнууд оролцсон байна.

2.3.3. Төрийн аудитын байгууллагын чадавхийг дээшлүүлэх, ажилтнуудын мэргэжлийн тасралтгүй сургалтын хөтөлбөрийг боловсруулах зорилгоор төсөл боловсруулсан бөгөөд уг төсөл 2016 онд Дэлхийн банкны буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжих юм.

2.4. Ерөнхий аудиторын тушаалаар батласан журам:

2.4.1. Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын, төрийн аудитын байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах, санхүүгийн тайлангийн аудитад итгэл үзүүлэхэд баримтлах, хөндлөнгийн хараат бус төрийн хяналтын байгууллага үүсэн байгуулагдсаны 20 жилийн ойг утган төрийн аудитын шилдэг бүтээл шалгаруулах журмуудыг боловсруулж, Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар батлан хэрэгжүүлэв.

2.4.2. Төрийн аудитын тухай хуулийн дагуу төрийн аудитын байгууллагын цалингийн Төрийн аудит /ТА/ сүлжээг шинээр боловсруулсан бөгөөд Төрийн аудитын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.4, 13 дугаар зүйлийн 13.4.7, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2.3, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дугаар заалтыг үндэслэн төрийн аудитын ажилтнуудад аудитын мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журмыг боловсруулж, батлан хэрэгжүүлэв.

2.4.3. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах /ерөнхий/ журмыг боловсруулан мөрдөж, Төрийн аудитын байгууллагад мэдээллийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоог бий болгох, мэдээллийн сүлжээ, системийн найдвартай ажиллагаа, мэдээллийн сангийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, гаднаас болон дотоодоос учирч болох халдлага, аюул заналаас урьдчилан сэргийлэх, засаж, сэргээх, хариу арга хэмжээ авах ажлыг зохион байгуулж байна.

¹ давхардсан тоогоор



2.5.Хуулийн төсөлд өгсөн санал:

2.5.1.Үндсэн хуулийн өөрчлөлтөд төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг хэрхэн тусгах талаар санал боловсруулж, уг саналын төслийг УИХ-ын ажлын хэсэгт хүргүүлэв.

2.5.2.Хяналтын тухай, Төсвийн тухай, Төсвийн тогтвортой байдлын тухай, Хүний хөгжлийн сангийн тухай, Нийтийн сонсголын тухай, Эрүүгийн хэрэг шалгах тухай, Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Аудитын тухай, Төрийн албаны тухай хуулиудын төсөлд төрийн аудиттай холбоотой 50 санал боловсруулж холбогдох албан тушаалтан, байгууллагуудад хүргүүлсэн бөгөөд уг саналын дийлэнх нь хуулийн төсөлд тусгагдан УИХ-аар батлагдсан байна.

2.6.Аудитын чанарын баталгаажуулалт:

2.6.1.2015 онд Үндэсний аудитын газрын 32 санхүүгийн тайлангийн, 5 гүйцэтгэлийн, 4 нийцлийн нийт 41 аудитад чанарын баталгаажуулалт хийлээ.



2.6.2.Архангай, Завхан, Увс, Ховд, Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Хөвсгөл аймгийн Аудитын газруудын гүйцэтгэсэн санхүү, гүйцэтгэл, нийцлийн аудитад чанарын баталгаажуулалт хийж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллав.

2.6.3.Төрийн аудитын байгууллагаас тогтоосон болон албан тушаалтнуудад өгсөн 376 төлбөрийн акт, албан шаардлагын хууль эрх зүйн үндэслэлийг хянаж, зохих зөвлөгөө өгч ажилласан.

Гурав. Төсвийн тухай хууль, УИХ-ын шийдвэрээр тогтоосон цаглабарт аудитын талаар

3.1.Санхүүгийн аудитын талаар.

3.1.1.Засгийн газрын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар 7400.7 тэрбум төгрөгийн алдааг залруулж, өглөг авлагыг тооцоо нийлж баталгаажуулаагүй, хугацаа хэтэрсэн, илүү, дутуу тайлагнасан, олгосон зээлд гэрээ байгуулаагүй зэрэг зөрчил илэрч, 3601.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, үр ашгийг дээшлүүлэх 8, үр нөлөөг сайжруулах 8, нийтдээ 16 зөвлөмж өгч, хязгаарлалттай санал дүгнэлт өгчээ.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 750, аудитын өртөг 72.4 сая төгрөг

3.1.2.Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар 224.3 тэрбум төгрөгийн материаллаг алдааг залруулж, 3.3 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 96 байгууллагад 222.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах 89 зөвлөмжийг өгөв. Энэ аудитад улсын төсвийн 32 ерөнхийлөн захирагч, Нийгмийн даатгалын сан, Хүний



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

хөгжил сангийн санхүүгийн тайлан хамрагдаж, Гадаад хэргийн сайдын төсвийн багцын санхүүгийн тайлан хязгаарлалттай санал дүгнэлт авсан байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 500, аудитын өртөг 48.3 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 3057.4 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 68.3 төгрөг.

3.1.3. Орон нутгийн 22 төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн тайлангийн аудитаар 157.8 тэрбум төгрөгийн алдааг залруулж, 2.3 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 70.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, 318 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах зөвлөмж өгчээ. Дархан-Уул, Өвөрхангай, Хөвсгөл аймаг, Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн тайлан хязгаарлалттай дүгнэлт авсан байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 1900, аудитын өртөг 185.4 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 2298.9 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 12.4 төгрөг.

3.1.4. Гадаад орнуудын хандивлагч байгууллагуудын хөрөнгөөр санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөрийн аудит. Чингис бондын санхүүжилтээр хэрэгжиж байгаа Дэд бүтэц, эрчим хүч, Таван толгойн цахилгаан станц, Эгийн голын усан цахилгаан станц, Гудамж төслүүд болон Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк болон бусад гадаад орнуудын хөрөнгийн санхүүжилтээр хэрэгжиж буй 14 төсөл, нийт 19 төслийн санхүүгийн тайландаа аудит хийж, зөрчилгүй дүгнэлт өгөв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 450, аудитын өртөг 43.5 сая төгрөг.

3.1.5. Хараат бус аудитын компанийн гүйцэтгэсэн аудит. Төрийн аудитын тухай хуулийн дагуу гэрээ байгуулсан хараат бус аудитын 45 компани 188 төсөвт байгууллага, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын 2014 оны санхүүгийн тайландаа аудит хийж, аудитаар 78.6 тэрбум төгрөгийн зөрчил арилгах албан шаардлага өгч, 103.0 сая төгрөгийн төлбөр барагдуулах акт тогтоож, 166 буюу 88.3 хувьд зөрчилгүй, 19 буюу 10.1 хувьд хязгаарлалттай дүгнэлт өгч, 3 байгууллагын санхүүгийн тайландаа дүгнэлт өгөхөөс татгалзжээ. Аймаг, нийслэлийн аудитын газар хийсэн санхүүгийн аудитын 904 буюу 24.1 хувийг хараат бус аудитын компаниар гэрээний дагуу хийлгүүлж дүгнэлт гаргуулжээ.

Хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 103.0 сая төгрөг.

3.1.6. Төрийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлангийн аудитад 79 аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсанас 68 нь зөрчилгүй, 10 нь хязгаарлалттай санал дүгнэлт өгч, 1 байгууллагад дүгнэлт өгөхөөс татгалзсан байна. 2014 онд 38 төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллага 170.5 тэрбум төгрөгийн алдагдалтай ажилласан нь өмнөх онтой харьцуулахад аж ахуйн нэгжийн тоо 17-оор буурсан боловч алдагдлын хэмжээ 24.5 тэрбум төгрөгөөр өсчээ.




3.2. Гүйцэтгэлийн аудитын талаар.


3.2.1. Монгол Улсын 2014 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл (УАГ-ГАГ/2015/НТГ)

2014 оны улсын, орон нутгийн, хүний хөгжлийн сангийн, нийгмийн даатгалын сангийн төсвийн гүйцэтгэлд Төсвийн тухай хуульд заасан цаглабрын дагуу аудит хийж, нэгдсэн төсвийн орлого, тэнцэл болон өрийн хэмжээ УИХ-аас баталсан төсвийн хүрээний мэдэгдлийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй байна гэсэн дүгнэлт хийлээ.

Засгийн газар болон ТЕЗ-дын үйл ажиллагааны хөтөлбөрийн агуулга, бүрэлдэхүүн, хүрэх үр дүн, шаардагдах нөөцийг тодорхойлох, түүнд суурилан төсвийг төлөвлөх, гүйцэтгэлийг тайлагнах нэгдсэн арга зүй, зохион байгуулалтын асуудлыг боловсруулж шийдвэрлэх, хэрэгжүүлэх зөвлөмжийг өгч, аудитын тайланг Ерөнхий аудиторын 2015 оны 154 дүгээр тушаалаар батлан, УИХ, холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэв.



Аудитад зарцуулсан хүн-өдөр 2370, аудитын өртөг 228.9 сая төгрөг.



3.2.2. Улс, орон нутгийн 2014 оны хөрөнгө оруулалтын хэрэгжилт үр дүн (УАГ-ГАГ/2015/01-ГА)
Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулиар 3,328.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 1,180.9 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр батлагдсан 855 төсөл, арга хэмжээг аудитад хамрууллаа. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнээс 466 нь бүрэн хэрэгжиж, 22 нь хэрэгжээгүй, 367 нь дутуу хэрэгжилттэй буюу хэрэгжих хугацаа болоогүй байна. Төсвөөс 2014 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт, үр дүнд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитаар 53.9 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах акт, албан шаардлага өгөв.


Аудитын тайланг улсын төсвийн хөрөнгө оруулалтын 837 барилга, байгууламжийн хэрэгжилтийн 25-58 төрлийн мэдээллийг агуулсан цахим мэдээллийн хамт УИХ болон Байнгын хороодод танилцуулж хэлэлцүүлэв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 9794, аудитын өртөг 946.1 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 53.9 тэрбум төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 57.0 төгрөг.



3.2.3. Монгол Улсын 2014 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт (УАГ-ГАГ/2015/02-ГА) Аудитаар Монгол Улсын 2014 оны эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгагдсан 104 арга хэмжээний хэрэгжилтэд үнэлгээ өгч, дүгнэлт гаргалаа.

Үндсэн чиглэлд тусгагдсан 32 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 62 арга хэмжээ хэрэгжих шатандаа, 10 төсөл, арга хэмжээ хэрэгжээгүй байна. 2010-2014 оны үндсэн чиглэлийн хэрэгжилтэд судалгаа хийж үр дүнд боловсруулалт хийлзээ. Үндсэн чиглэлийн төлөвлөлт, хэрэгжилт тайлагналыг боловсронгуй болгох чиглэлээр 3 зөвлөмж өгөв.



Аудитын тайланг МУ-ын Ерөнхий аудиторын 2015 оны 103 дугаар тушаалаар баталгаажуулан, УИХ, холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 1725, аудитын өртөг 166.6 сая төгрөг.


3.2.4. 2016 оны төсвийн төсөлд өгсөн санал. Төрийн аудитын байгууллага улс, орон нутгийн төсвийн төсөлд 28.9 тэрбум төгрөгөөр орлого нэмэгдүүлэх 68 санал, 645.4 тэрбум төгрөгөөр үр ашиг дээшлүүлэх 144 санал боловсруулсан бөгөөд тэдгээрээс орлого нэмэгдүүлэх саналын 60.8 хувь, үр ашиг дээшлүүлэх саналын 31.9 хувь нь дэмжигдэж улс, орон нутгийн төсөвт тусгагджээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2016 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2017-2018 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар тогтвортой байдлыг хангах үндсэн 9 шалгуур үзүүлэлтээс 2016 оны нэгдсэн төсвийн төсөл 5 үзүүлэлтийг хангаагүй, зарим орлогыг биелэгдэх боломжгүйгээр төлөвлөсөн, зарлагын санхүүжилтын хүндрэл нь оны төгсгөлд төсвийн тодотгол хийх гарцаагүй байдал тулгардаг практик давтагдах магадлалтай байна гэж дүгнэв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 140, аудитын өртөг 13.5 сая төгрөг болж, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 223.2 тэрбум төгрөг.

Дөрөв. УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолын дагуу хийсэн аудитын талаар

4.1. Гүйцэтгэлийн аудитын талаар.



4.1.1. Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан “Ажилтай, орлоготой Монгол хүн”, “Эрүүл чийрэг Монгол хүн” дэд хөтөлбөрийн хэрэгжилт үр дүн” (УАГ-ГАГ/2015/03-ГА) Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт “Ажилтай, орлоготой Монгол хүн” бүлэгт 163 зорилт, 586 арга хэмжээ, “Эрүүл чийрэг Монгол хүн” бүлэгт 22 зорилт, 49 арга хэмжээ тусгажээ.



Аудитаар “Ажилтай, орлоготой Монгол хүн” хөтөлбөр 46.8 хувийн хэрэгжилттэй, “Эрүүл чийрэг Монгол хүн” хөтөлбөр 54.3 хувийн биелэлттэй байна гэж дүгнэн, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах 6 зөвлөмж өгөв.

Аудитын тайланг Ерөнхий аудиторын 2015 оны 166 дугаар тушаалаар батлан, УИХ, холбогдох Байнгын хороод болон яамдад хүргүүлэв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 3960, аудитын өртөг 275.6 сая төгрөг.

4.1.2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэрэгжилт үр дүн(УАГ-ГАГ/2015/04-ГА) Монгол Улсад 2014 оны байдлаар 18 хуулийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн 257 заалт хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бөгөөд түүний татварын орлогод эзлэх хувийн жин жил бүр өсч, 2010 онд 4.0 хувь байснаа 2014 онд 11.7 хувьд хүрчээ.



2014 онд хууль тогтоомжийн дагуу үзүүлсэн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 720.8 тэрбум төгрөгт хурсэн нь нэгдсэн төсвийн нийт алдагдал /865.1 тэрбум төгрөг/-ын 83.3 хувьтай тэнцэж байна.

Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хуулийн зарим заалт нь хоёрдмол утга санаатай, тодорхой бус, Засгийн газраас татварын чөлөөлөлт үзүүлэх барааны жагсаалтыг батлахдаа хамрах хүрээг өргөсгөж хөнгөлөлт, чөлөөлөлт хэт хавтгайрах нөхцлийг бүрдүүлсэн байна гэж дүгнэлээ.

Аудитаар зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 5 зөвлөмжийг Сангийн сайд, ГЕГ-ын болон ТЕГ-ын дарга нарт өгч, аудитаар 37.5 сая төгрөгийн акт тогтоон барагдуулав.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 1333, аудитын өртөг 128.8 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 630.8 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 4.89 төгрөг.

4.1.3.Хил орчмын байгаль орчныг хамгаалах талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдал (УАГ-ГАГ/2015/08-ГА) ОХУ-ын Тооцооны танхимтай хамтран Хил орчмын байгаль орчны талаарх төрийн зохицуулалтын үр нөлөөт байдалд зэрэгцээ аудитыг хийж гүйцэтгэв.


Ойг түймрээс хамгаалах бие даасан хэлэлцээрт түймрээс учирсан хохирлыг хэрхэн шийдвэрлэх асуудал тусгагдаагүйгээс экологийн хохирлыг барагдуулах боломжгүй, улсын тусгай хамгаалалттай газраас ойг хамгаалах, хадгалах үйл ажиллагаа нь давамгайлж ойг зүй зохистой ашиглах, ой зохион байгуулалтын ажил хийх, ойн нөхөрлөлийн газрыг хамгаалалтын бүсэд оруулах зэргээр ойг эдийн засгийн эргэлтэд зөв оруулах, нөхөн сэргээлт хийх, үржүүлэлт хийх, ан амьтан амьдрах, үржих нөхцлийг сайжруулах талаар дутагдалтай ажиллаж байна гэж дүгнэж, үр өгөөж тооцох, хариуцлага дээшлүүлэх, хохирол барагдуулах, үр нөлөөг дээшлүүлэх 8 зөвлөмж өгөв.





Аудитад зарцуулсан хүн-өдөр 768, аудитын өртөг 74.2 сая төгрөг.

4.1.4. Уул уурхайн нөхөн сэргээлтийн хөрөнгийн төвлөрүүлэлт, зарцуулалт, үр дүн (УАГ-ГАГ/2015/05-ГА) Аудитаар ашигт малтмалын орд газарт тусгай зөвшөөрөл эзэмшигч 481 аж ахуйн нэгжийн байгаль орчны менежментийн болон уулын ажлын төвлөвлөгөөний дагуу 2013, 2014 онд гүйцэтгэсэн ажлын биелэлтийг тайлан мэдээ, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлтийн хэрэгжилттэй тулган дүгнэлт гаргав.



БОНХАЖЯ, УУЯ, МХЕГ, аймаг, сумын Засаг дарга нарын ажлын уялдаагүйгээс холбогдох мэдээллийг солилцдоггүй, хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагаанд тавих хяналтыг хамтран хэрэгжүүлдэггүй гэсэн дүгнэлтийг хийж, үр өгөөж тооцох, хариуцлага дээшлүүлэх, хохирол барагдуулах, үр нөлөөг дээшлүүлэх 9 зөвлөмжийг өгөв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 4472, аудитын өртөг 432.0 сая төгрөг.

4.1.5. Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүн" (УАГ-ГАГ/2015/07-ГА) Төрийн өмчит их, дээд сургуулиудын 2013-2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитад МУИС, АШУУИС, ХААИС, МУБИС, ШУТИС, СУИС, ХСИС, БХИС, Үндэсний тагнуулын академи, Удирдлагын академи, Тээврийн дээд сургууль, Монгол-Германы хамтарсан технологийн дээд сургууль нийт 12 их, дээд сургуулиуд хамрагдсан бөгөөд төрийн өмчийн их дээд сургуулиудын үйл ажиллагааны үр дүнг нь үнэлэх тодорхой тусгагдсан зорилт, хөтөлбөр байгаа эсэх, санхүү, хөрөнгийн нөөцөөр хангагдсан эсэхэд аудит хийж талбарын ажлыг гүйцэтгэж дуусаад тайлагналын үе шатны ажлыг хийж байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 576, аудитын өртөг 55.6 сая төгрөг.

4.1.6. Монгол-Оросын хамтарсан УБТЗ ХНН-ийн үйл ажиллагааны үр дүн (УАГ-ГАГ/2015/06-ГА) ОХУ-ын Тооцооны танхимтай хамтран Улаанбаатар төмөр замын ХНН-ийн 2012-2014 оны үйл ажиллагааны үр дүнд хийж буй аудитыг 2015 оны 3 дугаар сарын 31-нд эхлүүлсэн бөгөөд аудитын талбарын ажил дуусаж тайлагналын үе шатны ажил хийгдэж байна. ОХУ-ын Тооцооны танхимтай байгуулсан хамтарсан аудитын хэлэлцээрт нэмэлт өөрчлөлт орсон учир аудитын тайлангийн төсөлд нэмж мэдээлэл оруулж, боловсруулалт хийж байна.


Аудитад зарцуулсан хүн-өдөр 774, аудитын өртөг 74.8 сая төгрөг.

4.1.7. Эрдэнэт үйлдвэр ХК-ийн үйл ажиллагааны үр дүн (УАГ-ГАГ/2014/05-ГА) ОХУ-ын Тооцооны танхимтай хамтран Эрдэнэт үйлдвэр ХК-ийн үйл ажиллагааны үр дүнд аудит хийж, аудитын тайланг 2015 оны 3 дугаар сарын 24-ний өдөр ОХУ-ын Тооцооны танхимины коллеги, Монгол Улсын Үндэсний аудитын газрын удирдлагын зөвлөлийн хамтарсан хуралдаанаар хэлэлцэн, аудитын тайланг нууцын жагсаалтад оруулан баталгаажуулж УИХ-д хүргүүллээ.



Аудитад зарцуулсан хүн-өдөр 768, аудитын өртөг 74.2 сая төгрөг.

4.1.8. Эрчим хүчний салбарын төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн” (УАГ-ГАГ/2014/09-ГА)



Аудитад эрчим хүчний салбарын 25 төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллага хамрагдсан бөгөөд аудитаар эрчим хүчний салбарт удирдах, зохицуулах, судалгаа шинжилгээ, хяналт шалгалт хийх, зөвшөөрөл олгох үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудын чиг үүрэг давхардсан, зардал өндөр байна гэж дүгнэн, 1532.0 сая төгрөгийн акт тогтоож, 5200.0 сая төгрөгийн зөвлөмжийг арилгах албан шаардлага, 9 зөвлөмжийг Эрчим хүчний сайдад хүргүүллээ.

Аудитын тайланг Ерөнхий аудиторын 2015 оны 31 дүгээр тушаалаар баталгаажуулж, УИХ-ын Төсвийн Байнгын хороогоор хэлэлцүүллээ.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 512, аудитын өртөг 49.5 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 6732.0 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 136 төгрөг.

4.1.9. Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн үр дүн (УАГ-ГАГ/2014/06-ГА) Засгийн газраас гаргасан үнэт цаас болон Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, санхүүжүүлсэн төслийн хэрэгжилт, Хөгжлийн банкны 2014 оны үйл ажиллагааны үр дүнд аудит хийв.

Засгийн газрын тогтоолоор төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх болон хэрэгжүүлэх байгууллага, олгох мөнгөн дүн хугацааг шууд заасан, түүнчлэн эрсдэл, үр ашгийг нарийвчлан судалж тодорхойлоогүй байна гэсэн дүгнэлт хийлээ.

Аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудиторын 2015 оны 41 дүгээр тушаалаар баталгаажуулж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн 5 зөвлөмж бүхий тайланг УИХ-ын Төсвийн Байнгын хороонд хүргүүллээ.



Аудитад зарцуулсан хүн-өдөр 60, аудитын өртөг 5.8 сая төгрөг.


4.2. Нийшилийн аудитын талаар.

4.2.1. Концессийн тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 4 зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад өгч, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн орчин тодорхой хэмжээнд бүрдэж байгаа ч Концессын тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг өгч, аудитын тайланг баталгаажуулан УИХ-д хүргүүллэв.

Концессын тухай хуулийн хэрэгжилтийг УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд мэдээлээгүй, концессоор хэрэгжүүлэхээр төсөл арга хэмжээг тэргүүлэх ач холбогдолтойг эрэмбэлээгүй, концессын журмыг боловсруулаагүй, концессын талаарх



нэгдсэн бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлээгүй зэрэг зөрчил илэрч, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах 4 зөвлөмж өгөв.




Аудитад зарцуулсан хүн-өдөр 44, аудитын өртөг 4.2 сая төгрөг.

4.2.2. Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт, төлбөр тооцооны байдалд хийсэн аудитаар 2,213.4 мянган ам.долларыг төсөвт төлүүлэхээр төлбөрийн акт тогтоож, 11 байгууллагад 626.5 мянган ам.доллар, 518.0 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар албан шаардлага хүргүүлэв.

Газрын тосны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй, гэрээлэгч компаниуд Бүтээгдэхүүн хуваах гэрээнд тусгагдсан төлбөрийг бүрэн төлөөгүй байна гэсэн зөрчил илэрч, үр ашгийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах 12 зөвлөмж өгөв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 192, аудитын өртөг 18.5 сая төгрөг,



4.2.3. Тариалангийн тухай хуулийн хэрэгжилт, үр дүн, төрөөс газар тариалангийн салбарт хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөрийн үйл ажиллагаанд хийсэн аудитаар илэрсэн 4,608.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 5 зөвлөмжийг Хүнс, хөдөө аж ахуйн сайдад өгч, тариалангийн тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж ажиллаагүй байна гэсэн дүгнэлт өгөв.

Аудитаар хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан, бүтээгдэхүүн хуваах гэрээний биелэлтэд тавих хяналт хангалтгүй, гаргасан журам нь Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг зөрчсөн зөрчлүүд илэрсэн байна.


Аудитад зарцуулсан хүн-өдөр 42, аудитын өртөг 4.1 сая төгрөг.



4.2.4. УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газарт өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 4 заалт бүхий зөвлөмжийг Монгол Улсын Ерөнхий сайдад хүргүүлж, УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газарт өгсөн үүрэг даалгавруудын хэрэгжилт хангалтгүй байна гэсэн дүгнэлтийг өгч тайланг баталгаажуулан УИХ-д хүргүүлэв.

УИХ-ын Байнгын хороодоос Засгийн газарт 21 тогтоолоор хугацаатай 27 даалгавар өгөгдснөөс хугацаандаа хэрэгжсэн 11, хэрэгжээгүй 9, хэрэгжилт тодорхойгүй 7 байна. Засгийн газар УИХ-ын Байнгын хороодоос өгсөн үүргийг бүрэн хангаагүй, хяналт сул, үнэн зөв тайлагнаагүй зөрчил илэрлээ.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 192, аудитын өртөг 18.5 сая төгрөг.



4.2.5. Монгол Улсын Ерөнхий сайдын 2013 оны төсвийн багцаас хэрэгжүүлсэн оношлогооны төв байгуулах төслийн хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 7 зөвлөмжийг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Эрүүл мэндийн сайдад хүргүүлж, оношлогооны төвтэй болсноор хөдөө орон нутгаас нийслэл хот руу ирж оношлогоо, шинжилгээ хийлгэх иргэдийн тоо буурчээ гэсэн дүгнэлтийг өгөв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 1750, аудитын өртөг


169.0 сая төгрөг.

4.2.6. Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчилд нийт 4.6 тэрбум төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 49.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, үр ашигийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах 13 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлж, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт хангартгүйгээс зөрчил өмнөх оноос өссөн байна гэсэн дүгнэлт өглөө.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж буй орон нутгийн удирдлага, ажил хариуцсан ажилтнуудын ажлын хариуцлагагүйгээс зөрчлийн хэмжээ, мөнгөн дүн өмнөх оноос 2 дахин өссөн байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 8453, аудитын өртөг 816.6 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 4600.0 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 5.63 төгрөг.

4.2.7. Засгийн газрын тусгай сангийн үйл ажиллагааны үр дүнд хийсэн аудитаар илэрсэн зөрчилд нийт 11.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 1,264.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, үр ашигийг дээшлүүлэх, үр нөлөөг сайжруулах 10 зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлэв.



Авто замын сангийн үйл ажиллагааг зохицуулах Авто замын санг төлөвлөх, түүнд хөрөнгө төвлөрүүлэх, захиран зарцуулах журамд заасан байгууллага нь татан буугдсан, эрх үүрэг нь шилжсэн байхад уг журамд нэмэлт өөрчлөлт оруулаагүй байна.

Соёл, урлаг хөгжүүлэх сангийн ажлын алба татан буугдаж сангийн чиг үүрэг нь БСШУЯ-д шилжсэн тул тус сангийн дүрэм, журмыг хуульд нийцүүлэн шинэчлэн боловсруулах, сангийн хөрөнгийн эх үүсвэрийг бодитой төлөвлөх, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

Дархлаажуулалтын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх сайн дурын дархлаажуулалт болон урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай иргэн, байгууллага аж ахуйн нэгжид ажиллаж буй иргэдийг бүрэн хамруулж чадахгүй байна.

Шинжлэх ухаан, технологийн сангийн хөрөнгөөр хэрэгжих шинжлэх ухаан, технологийн төсөл, сэдэв сонгон шалгаруулалт, төслийг батлах үйл ажиллагааг холбогдох журмын дагуу зохион байгуулаагүй, Засгийн газрын 2014 оны 301 дүгээр



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

тогтоолоор баталсан Шинжлэх ухаан технологийн төсөл хэрэгжүүлэх журамд заасны дагуу хяналт шалгалтын ажилд авсан 1 хувийн хөрөнгө болон төслийн санхүүжилтээс 514.1 сая төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан, 750.3 сая төгрөгийн зээлийн авлагатай байгаа зөрчлүүд илэрсэн байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 428, аудитын өртөг 41.3 сая төгрөг, хүлээн зөвшөөрөгдсөн үр өгөөж 646.6 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 15.6 төгрөг.

4.2.8. "Үнэ тогтвортжуулах хөтөлбөрийн хэрэгжилт"-ийн байдалд хийгдэж байгаа аудитаар Засгийн газар, Монгол банктай хамтран хэрэгжүүлсэн "Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортжуулах", "Барилгын салбарыг дэмжих, улмаар орон сууцны үнийг тогтвортжуулах", "Нүүрсний аюулгүйн нөөц бүрдүүлэх, түлш, эрчим хүчний салбарын өвөлжилтийн бэлтгэл хангах, эрчим хүчний үнэ, тарифыг тогтвортжуулах", "Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортжуулах", "Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах" дэд хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд аудит хийж, аудитын тайлангийн төслийг удирдлагын хяналтад шилжүүлсэн байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 129, аудитын өртөг 12.5 сая төгрөг.

4.2.9. МҮОНРТ-ийн 2012-2014 онд Улсын төсвөөс олгосон хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах 8 зөвлөмжийг МҮОНРТ-ийн үндэсний зөвлөл, МҮОНРТ-ийн Ерөнхий захиралд өгч, МҮОНРТ-д улсын төсвөөс олгосон санхүүгийн дэмжлэгийг зарцуулах хууль, эрх зүйн зохицуулалт хангалтгүй байна гэсэн дүгнэлт өгөв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 172, аудитын өртөг 16.6 сая төгрөг.

4.2.10. Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсрол олгох талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг барагдуулах, төрөөс төрийн бус өмчийн ерөнхий боловсролын сургуулиудад баримтлах нэгдсэн бодлого байхгүй байна гэсэн дүгнэлтийг өгөв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 3072, аудитын өртөг 296.7 сая төгрөг.

Тав. Бусад аудитын талаар

5.1. Улаанбаатар хотын шинэ нисэх онгоцны буудлын төслийн үйл ажиллагаа, үр дүн, УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны 2015 оны 4 дүгээр тогтоолоор өгсөн үүргийн хэрэгжилтэд Ерөнхий аудиторын батласан төлөвлөгөө, хуваарийн дагуу аудит хийж УИХ-ын Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэв.


Аудитад зарцуулсан хүн-өдөр 200, аудитын өртөг 19.3 сая төгрөг.

5.3. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийх аудит. Төрийн аудитын байгууллага Монгол Улсын Ерөнхий аудиторын батласан нэгдсэн төлөвлөгөөний дагуу төрийн болон орон нутгийн өмчтэй үйлдвэр, компани, төсвийн 5804 байгууллагуудын Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд 2015 оны эхний хагас жилд аудит хийж, илэрсэн зөрчлийг арилгах зөвлөмж, тайланг баталгаажуулан



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

холбогдох байгууллагуудад хүргүүлж, 394 байгууллагын дарга, төсөв захирагч нарт хууль хэрэгжүүлэх, зөрчлийг арилгах хугацаатай үүргийг албан шаардлагаар өгч ажиллав.



Эдгээр байгууллагууд нь Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д “Байгууллага нь шилэн дансны мэдээллийг өөрийн цахим хуудсаар хүргэх ...” гэж заасны дагуу 96.8 хувь буюу 5617 байгууллага төсвийн ерөнхий мэдээлээ байршуулснаас 4868 байгууллага нэгдсэн цахим сүлжээ, байгууллагын цахим сүлжэээнд 749 байгууллага мэдээллийн самбарт байршуулж, 187 байгууллага шилэн дансны мэдээллийг байршуулаагүй байна.

2015 оны сүүлийн хагас жилд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн байдалд хийх аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээ, хөтөлбөрийг боловсруулан аудитыг гүйцэтгэж байна.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 140, аудитын өртөг 13.5 сая төгрөг.

5.4.УИХ-ын Өргөдлийн, Эдийн засгийн, Төсвийн Байнгын хороодоос ирүүлсэн хүсэлтийн дагуу төрийн албан тушаалтны буруутай үйл ажиллагаанаас шалтгаалж ажлаас үндэслэлгүй халагдсан ажилтнуудад олгосон нөхөн төлбөрт төсвөөс зарцуулсан хөрөнгийн судалгаа, авто замын төслүүдийн хэрэгжилтийн танилцуулга, Засгийн газраас гаргасан Чингис, Самурай бондын хөрөнгийн зарцуулалт, Хөгжлийн банкны хуулийн хэрэгжилт, Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжсэн төслийн тайлбарыг гаргаж хүргүүлэв.

Аудитад зарцуулсан хүн-өдөр 40, аудитын өртөг 3.9 сая төгрөг.

Зургаа.Аймаг, нийслэлийн Аудитын газрын гүйцэтгэсэн аудитын талаар

2015 онд аймаг, нийслэлийн Аудитын газруудын хийсэн аудитаар 1.5 их наяд төгрөгийн зөрчлийг илрүүлж, 683.5 төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 3042 албан шаардлагаар өгч, 9.8 тэрбум төгрөгийн 2003 төлбөрийн акт тогтоосноос төлбөрийн акт, албан шаардлагаар 11.4 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт оруулж, 1074 албан тушаалтанд хариуцлага тооцуулах санал хүргүүлж 67.9 хувь болох 729 нь бүрэн хэрэгжиж, 23.2 хувь нь хэрэгжилтийн хугацаа болоогүй байна.

2015 онд аймаг, нийслэлийн Аудитын газрууд ИТХ-ын хүсэлтээр нийтдээ 52 аудит хийж, холбогдох арга хэмжээг тухайн бүрд нь гаргуулж асуудлыг шийдвэрлэсэн байна. (Хавсралт №2-оос үзнэ үү.)

Аймаг, нийслэлийн Аудитын газруудын /давхардсан дүнгээр/ аудитад зарцуулсан хүн-өдөр 66040, аудитын өртөг 6006.3 сая төгрөг, зардлын нэг төгрөгт ногдох үр өгөөж 57.5 төгрөг.



Долоо. Төрийн аудитыг дэмжих үйл ажиллагааны талаар

7.1 Төрийн аудитын байгууллагын удирдлага, эрх зүйн орчин

Монгол Улсын Ерөнхий аудитор 2015 онд төрийн аудитын технологи, арга зүй, үйл ажиллагааг боловсронгуй болгох, шинэчлэх чиглэлээр 341 тушаал батлан гаргасан байна.

Төрийн аудитын байгууллага босоо тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан дүрэм журмыг шинэчлэн боловсруулж 32 журам, 9 дүрэм, 1 удирдамж, 2 зөвлөмж, 2 баримт бичиг, 2 зааврыг үйл ажиллагаандaa мөрдөн ажиллаж байна.

Мөн хэрэгцээ шаардлагад үндэслэсэн 10 хөтөлбөр, 5 төлөвлөгөөг хэрэгжүүлж байна.

Төрийн албан хэрэг хөтлөлтийн зааврын дагуу Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааг стандартын дагуу зөв баримтжуулах, мэдээлэл, тоо бүртгэлийн санд оруулах, шуурхай хянан шийдвэрлүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд үүссэн баримт бичгийг зөв ангилж төрөлжүүлэх, эмх цэгц, бүрдлийг сайжруулах, нууцлах, хадгалах, хамгаалах, санамжийн архив үүсгэх зэрэг ажлыг зохион байгууллаа.

2015 онд Үндэсний Аудитын газарт ирсэн нийт 1835 баримт бичигт “Төрийн албан хэрэг хөтлөлтийн үндсэн заавар”-ын дагуу шийдвэрлэлтэнд нь хяналт тавив.


Авлигын эсрэг соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, 19 шалгуур үзүүлэлтээр тайлагнан, үнэлгээ жил бүр өссөн үзүүлэлттэй байна.

2015 онд Үндэсний аудитын газар, Монгол Улсын Ерөнхий аудиторт хандаж нийт 102 өргөдөл, санал, хүсэлт ирүүлснээс аудиттай холбоотой 18, хүний нөөцтэй холбоотой 84 өргөдөл ирүүлснийг шийдвэрлэсэн.

Авлигын эсрэг сүлжээний уулзалтаар баталсан Истанбулын авлигын эсрэг үйл ажиллагааны үнэлгээний тайланд Монголын Үндэсний аудитын газрын зохион байгуулалт болон үйл ажиллагааны бие даасан байдлыг олон улсын стандартад



АВЛИГЫН ЭСРЭГ ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙДАЛ





нийцүүлэн бэхжүүлэх, төсөв, ажилчдын цалин хөлс тогтоох асуудлын бие даасан байдлыг хангах, Ерөнхий аудиторын тушаалаар баталсан аудитын тайланг хэвлэн нийтэлж байх зөвлөмжийг тусгасан байна.

8.2. Хүний нөөцийн удирдлага

Төрийн аудитын байгууллага хүний нөөцийн нэгдсэн үйл ажиллагааг зохицуулан, байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг, Хүний нөөцийн хөгжлийн болон нийгмийн хамгааллын хөтөлбөр зэргийг боловсруулан мөрдөн ажиллаж байна.

Системийн хэмжээний 389 ажилтан албан хаагчдын хувийн хэргийн бурдэл, баяжуулах ажлыг "Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам"-ын дагуу бүрэн хийж, төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний өөрчлөлтийг тогтмол бүртгэж мэдээллийн бааз бүрдүүлэн, тайланг Төрийн албаны зөвлөлд хүргүүлж байна.

Төрийн аудитын байгууллагын ажилтан албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийг Авлигын эсрэг хуулийн 10.3, 10.4, 11.3 дахь заалтын дагуу хугацаанд нь хүлээн авч, мэдээ тайланг хүргүүлэн ажиллав.


Төрийн аудитын байгууллагын ажилтнуудаас авах мэргэшлийн шалгалтын журмын дагуу 5, 10, 15, 20 жил ажилласан 37 ажилтан шалгалтад хамрагдан 100 хувийн амжилт үзүүллээ.

Эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулан, спортын үйл ажиллагааг зохион байгуулж УИХ-ын дэргэдэх байгууллагуудын "Шилжин явах цомын төлөө" тэмцээнд багаараа 5 дугаар байрт шалгарч, ахмад настанд сар шинийн болон ахмадын баяраар хүндэтгэл үзүүлэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүллээ.

8.3. Төсөв, санхүү, бүртгэл

2015 оны төсвийн төслийг хөтөлбөрт суурилсан бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх төсвийн төлөвлөлтийн арга зүйг баримтлан "Аудитын өртөг тооцох аргачлал"-аар боловсруулсан бөгөөд Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуулиар Монгол Улсын Ерөнхий аудиторын төсвийн багц 9.7 тэрбум төгрөгөөр батлагдсан бөгөөд 9.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарлаа.

Мөн төсвийн шууд захирагчаас төсвийн холбогдох мэдээ, тайланг тухай бүр авч нэгтгэн нэгдсэн дүн, мэдээг тогтоосон хугацаанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захираганы төв байгууллагад хүргүүлэн төсвийн өр, авлага үүсгэхгүй байхаар холбогдох зохицуулалтуудыг хийж хяналт тавин төсвийн сахилга, хариуцлагыг ханган ажиллалаа.



Монгол Улсын шилэн дансны тухай хууль 2015 оны 1 дүгээр сарын 1-нээс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан доорх арга хэмжээг зохион байгуулж ажиллав.

- Төрийн аудитын байгууллага хуульд нийцүүлэн дотооддоо мөрдөж ажиллах хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд Монгол Улсын Ерөнхий аудитор бусад төрийн аудитын байгууллагын удирдлага, нягтлан бодогч наарт хөтөлбөрийг танилцуулж хуулийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллах асуудлаар мэдээлэл хийлгээ.
- Төрийн аудитын байгууллагын Удирдах ажилтны зөвлөгөөнд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зохион байгуулалтын талаар Сангийн яамнаас мэргэжилтнээр мэдээлэл хийлгэлээ.
- Шилэн дансны тухай хууль болон Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 384 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох” тухай журам, ном гарын авлагаар төрийн аудитын байгууллагын ажилтнуудыг ханган ажиллалаа.
- Дээрх журамд заасан аргачлалын дагуу шилэн дансанд тавигдах мэдээллийн жагсаалтыг гаргаж төрөлжүүлж холбогдох маягаар мэдээллийг цаг тухайд нь оруулах боломжийг бүрдүүлэв.
- Үндэсний аудитын газрын [“audit.mn”](http://audit.mn) сайтад Төрийн аудитын байгууллагын төсвийн захирагч тус бүрээр шинээр “ШИЛЭН ДАНС” цэсийг үүсгэж түүнд журамд заагдсан аргачлал, маягтын дагуу мэдээллийг тогтмол оруулж, тодруулга өгөх албан тушаалтны нэр, утас, цахим хаягийг байршуулж, өөрчлөлт орсон тухай бүр өмнөх мэдээллийг цахим хуудасны архивт хадгалах, архивын мэдээллийн сан бүрдүүлэн нэг цэгээс бүх мэдээллийг бүрэн мэдээлж байхаар зохион байгуулж, төсвийн төвлөрүүлэн захирагч мэдээллийг хуулийн хугацаанд оруулж байгаа эсэхэд хяналт тавьж ажилласан.
- Төсөв, санхүүгийн бүх мэдээллийг хуулийн хугацаанд нь, бүрэн, шаардлага хангасан, олон нийтэд ойлгомжтой хэлбэрээр байршуулж, тогтмолжуулсан.
- Засгийн газрын 2015 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны тэмдэглэлийн дагуу Төрийн аудитын харьяа газруудад улирал бүр тайланг



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

гаргаж ирүүлж байх үүрэг чиглэл өгч, улирал бүр авч нэгтгэж ТЕЗ-ын шилэн дансны тайланг гаргаж хуулийн дагуу тогтоосон хугацаанд Сангийн яаманд хүргүүлэн ажиллалаа.

- Монгол Улсын Ерөнхий аудитор Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитын тайлангаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хамтран зохион байгуулсан зөвлөгөөнд нийтийн сонсгал хийсэн нь Төрийн байгууллагууд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хэрхэн хангаж байгаа талаар олон нийтэд хүргэхэд нэлөө үзүүлсэн арга хэмжээ болсон.
- Шилэн дансны тухай хууль болон түүнд нийцүүлж Засгийн газраас журмын хэрэгжилтийг хангуулах, мэдээллийг өөрийн цахим хуудсанд цаг хугацаанд нь байршуулж хэвшүүлэхтэй холбоотой сургалтуудыг зохион байгуулж ажиллалаа.

Дэлхийн банкнаас Монгол Улсын төсвийн санхүүгийн удирдлага, гүйцэтгэлийн тайландаа 2015 онд үнэлгээ хийлгээ. Тайлангийн PI-26-д хөндлөнгийн аудитын цар хүрээ, шинж байдал, зөвлөмжийн мөрөөр тавьж буй хяналтын талаар үнэлгээ хийж B+ гэж дүгнэлээ.

/ Үндэсний аудитын газрын 2015 оны төсвийн санхүүгийн тайлан, түүнд хийсэн аудитын дүгнэлтийг хавсаргав./

8.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагаа

2015 онд Төрийн аудитын байгууллагын хоёр талт харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлж, олон улсын байгууллагуудтай харилцаа тогтоон, аудитор, шинжээчдийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх олон улсын хөтөлбөр, сургалтад хамруулсан.



Аудитын дээд байгууллагуудын Олон улсын байгууллага (INTOSAI) -1996

ИНТОСАИ-н Байгаль орчны аудитын ажлын хэсэг -2004

ИНТОСАИ-н Олборлох аж үйлдвэрийн аудитын ажлын хэсэг – 2015



ИНТОСАИ-н олборлох аж үйлдвэрийн аудитын ажлын хэсгийн 2 дугаар уулзалтад Монгол Улсын Ерөнхий аудитор тэргүүтэй төлөөлөгчид оролцож, олборлох аж үйлдвэрийн аудитын чадавх ба хууль эрх зүйн орчин хэрхэн дээшлүүлэх талаар санал солилцож, олон улсын болон өөрсдийн туршлагыг хуваалцсан үр дүнтэй арга хэмжээ боллоо.



Аудитын дээд байгууллагуудын Азиийн байгууллага (ASOSAI) – 1996

ACOSAI-н Аудитын хорооны гишүүн – 2006, 2009, 2015



ACOSAI-н 2015-2018 онд ажиллах Аудитын хорооны гишүүний сонгуулиар Монгол Улсын Төрийн аудитын байгууллага гишүүнээр сонгогдсон нь ACOSAI-н 2015-2018 оны санхүүгийн үйл ажиллагаанд хөндлөнгийн хараат бус аудит хийж, дүгнэлт гаргах үүрэг хүлээж байна. Монгол Улсын Төрийн аудитын байгууллага З дахь удаагаа энэхүү өндөр хариуцлагатай үүрэгт ажилд сонгогдож байгаа нь Монгол Улсын Төрийн аудитын байгууллагын нэр хүнд олон улсын түвшинд өсөж байгаагийн илрэл юм.

Үндэсний аудитын газар ОХУ-ын Тооцооны танхимтай хамтран “Эрдэнэт үйлдвэр” ХК-ийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг хэлэлцэж, Улаанбаатар төмөр замын ХНН-д хийх хамтарсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг баталж, Хил орчмын байгаль орчныг хамгаалахад төрийн бодлогын үр нөлөө сэдэвт зэрэгцээ аудитыг хамтран хэрэгжүүлэх санамж бичигт гарын үсэг зурлаа.



БНХАУ-ын Үндэсний аудитын газар болон Монгол Улсын Үндэсний аудитын газар 2020 он хүртэл хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг байгуулж, гарын үсэг зурж баталгаажуулсан нь хоёр орны аудитын дээд байгууллагуудын хоёр талт харилцаа, хамтын ажиллагаа өргөжин, хөгжих боломж бурдэж байгаа юм.

Монгол Улс болон БНХАУ-ын Үндэсний аудитын газруудын аудитор, шинжээч нар Хөрөнгө оруулалтын аудит сэдвээр хамтарсан семинар зохион байгууллаа.



Хоёр талт хамтын ажиллагааны хүрээнд Кувейт Улсын Төрийн аудитын товчооноос “Газрын тосны аудит” сэдвээр, БНСУ-ын АДБ-гаас “Аудитын болон дотоод үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах” сэдвээр, Турк Улсын Тооцооны шүүхээс “Гүйцэтгэлийн аудит” сэдвээр зохион байгуулсан сургалтад Төрийн аудитын байгууллагын 26 ажилтан хамрагдаж, аудитын олон улсын стандарт, аудитын арга зүй, шилдэг туршлагаас суралцан, мэдлэг үр чадвараа дээшлүүллээ.



ИНТОСАИ-н Хөгжлийн хөтөлбөр сангаас санаачлан хэрэгжүүлж байгаа “Мэдээллийн технологийн аудит”, “Гамшгийн удирдлагын аудит”, “Улсын өрийн удирдлагын аудит” зэрэг хөтөлбөрүүдэд 9 ажилтан хамрагдаж, тухайн чиглэлээр мэргэшсэн сургагч багш нар бэлтгэгдэж байна.

8.5. Мэдээллийн технологийг нэвтрүүлсэн талаар:



Орчин үеийн дэвшилтэй технологи болох *Cloud Computing* буюу Үүлэн тооцооллыг Цахим Оффисын системд тулгуурлан програмын хөгжүүлэлт, тохируулгуудыг хийж гүйцэтгэсэн. Энэхүү ногоон технологийн тусlamжтайгаар ажилчид интернет хөтөч програмын тусlamжтайгаар өөрт ногдсон төрийн аудитын нэгдсэн сүлжээний хаягаар (жишээ:Bat.L@audit.local) “Цахим Оффис”-ын системд нэвтэрч нэгдсэн серверт файл байршуулж засварлах, шинээр үүсгэх, цахим архив үүсэх түүнийгээ орон зай хамааралгүй удирдах, бусадтай хамтран ажиллах боломжоор хангагдлаа.

Төрийн аудитын байгууллагын төв, орон нутгийн ажилтнуудад онлайн хурал болон сургалт зохион байгуулах *Lync* программыг нэвтрүүлж, аудитын болон дотоод үйл ажиллагааны сэдвээр сар бүр аймаг, нийслэлийн Аудитын газруудын тэргүүлэх аудитор, нягтлан бодогч, аудитор, шинжээч наарт сургалт хийж, хурал зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулж байна.



Төрийн аудитын нэгдсэн портал сайтыг шинээр хийж, өдөр тутмын мэдээ, мэдээлэл, шилэн дансны мэдээ, хууль, эрх зүй, стандарт, аудитын төлөвлөгөө, тайлан, зөвлөмж, албан шаардлага, төлбөрийн акт зэргийг ил тод мэдээлж байна

8.6. Аудитын сурталчилгааны талаар:

Гүйцэтгэсэн аудитын тайланг төрийн аудитын байгууллагын вэб сайтад байршуулав. 2015 онд audit.mn цахим хуудсанд нийтдээ 178.1 мянган хэрэглэгч хандаж мэдээлэл авч, байгууллагын сайт, дотоод мэдээллийн сан, *Facebook*, *twitter* хуудсанд нийт 676 контент, мэдээ мэдээлэл байршуулав.

Төрийн аудитын байгууллага үйл ажиллагааны талаар хэвлэл мэдээллийн байгууллагад 271 удаа мэдээлэл, ярилцлага өгсний гадна 2398 иргэн, байгууллагад аудитын тайлангийн талаар мэдээлэл гаргаж өгсөн байна.

Төрийн хяналтын 20 жилийн ойд зориулж “Royal HD” телевизтэй хамтран баримтат кино хийлгэж, “Төрийн аудитын байгууллагын өөрчлөлт шинэчлэлт” сэдвээр Өдрийн сонинд Мэлмий нүүр бэлтгэн нийтлүүлэв.

Төрийн аудитын үйл ажиллагаатай холбоотой болон бусад асуудлаар 465 мэдээлэл, хүсэлт хүлээн авсны 459 буюу 98.7 хувийг хугацаанд нь шийдвэрлэсэн ба 4 нь хугацаа болоогүй байна. Ирүүлсэн хүсэлт, мэдээллийн 4.7 хувь нь төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой, 37.2 хувь нь аudit хийх эрсдэлтэй асуудлыг, 56.6 хувь нь хүний нөөцтэй холбоотой сэдвийг хөнджээ.



Төрийн аудитын байгууллага албан хэргийн хөтлөлт, байгууллагын захирамжлал, зохион байгуулалт мэдээлэл баримт бичгүүдийг архивлах ажлуудыг зохих журмын дагуу албажуулж, архивт шилжүүлэн албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэгт амжилттай дүн үзүүллээ.

2015 онд 2306 албан бичиг ирж, ирсэн бичгийн хариутай, хариу шаардахгүй эсэхэд тэмдэглэгээ хийж, бүртгэл хяналтын картаар шийдвэрлэлтэд хяналт тавьж ажилласан бөгөөд 1463 албан бичгийг хуулийн хугацаанд холбогдох байгууллагуудад хүргүүлжээ.

8.7. Төрийн аудитын үйл ажиллагааны статистик мэдээ, тайлан:

Төрийн аудитын байгууллагын 2014 оны жилийн болон 2015 оны эхний хагас жилийн статистик мэдээллийг батлагдсан график, маягт, зааврын дагуу 27 нэгжээр 8 дэлгэрэнгүй хүснэгтээр хүлээн авч нэгтгэн дотоод сүлжээнд байршуулж архивт шилжүүлэв.

Төрийн хянан шалгах ба төрийн аудитын байгууллагын 1995-2014 оны ажлын үр дүнгийн зарим үзүүлэлтээр зэрэгцүүлсэн судалгаа хийж, уг судалгааг ашиглахад бэлэн болгов.

Аймаг, нийслэлийн аудитын газрын үйл ажиллагааны үр дүнг үнэлж, дүгнэх журмыг боловсруулж шалгуур үзүүлэлтуүдийн дагуу 2014 оны аймаг, нийслэлийн Аудитын газрын үйл ажиллагааг үнэлж дүгнэн тэргүүн, дэд, гутгаар, тусгай байр эзлүүлэв.

УИХ-ын Төрийн Байгуулалтын Байнгын хорооны 2013 оны 05 дугаар тогтоолын дагуу 2014 оны үйл ажиллагааны тайланд Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаалаар баталсан ажлын хэсэг системчилсэн үнэлгээ хийж, тайланг боловсруулан үйл ажиллагааны тайлангийн хамт хэвлүүлж хүргүүлэв.

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны 2014 оны 3 дугаар тогтоолын биелэлтийг гаргаж, УИХ-ын Тамгын газрын Хяналт, шинжилгээ үнэлгээний газарт хургуулэн 2015 онд аймаг, нийслэлийн ИТХ-ын захиалгаар хийх аудитын сэдвийн саналыг авч нэгтгэн боловсруулав.



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

Хавсралт №1

Төрийн аудитын байгууллагын 2003-2015 оны ажлын үр дүнгийн зарим үзүүлэлт

Үзүүлэлт	Х/Н	ОН										ДҮН			
		2003	2004	2005	2006	2007	2008	2009	2010	2011	2012	2013			
Санхүүгийн тайллангийн аудит	Т00	380	985	2,410	2,685	3,176	2852	2649	3172	3145	3771	4099	4543	4093	37,960
Гүйцэтгэлийн аудит	Т00	692	597	553	563	550	509	425	522	358	307	311	248	214	5,849
Нийцлийн аудит	Т00									40	156	196	187	157	736
Аудитын дүн	Т00	1072	1582	2963	3248	3726	3361	3074	3694	3543	4234	4606	4978	4464	44,545
Акт	Т00	512	432	875	843	824	1135	1358	1843	1827	2032	2638	2355	2035	18,709
Биелсэн	Тэрбум. төг	8.4	15.6	1.0	3.3	2.8	4.4	5	30.5	31.1	70.5	35.1	18.6	22.9	249.2
Албан шаардлага	Т00	307	223	514	426	571	794	963	1137	1040	1760	2223	2428	3195	15,581
Биелсэн	Тэрбум. төг	4.0	4.0	4.7	31.8	12.0	230.9	129.7	2403.5	395.7	1253.7	1088.3	2457.0	5548.3	13,566.0
Нийт төлбөр, зөрчлийн дүн	Өгсөн Биелсэн	14.8	19.6	5.7	35.1	14.8	235.4	134.7	2,434.0	426.8	1,324.2	1,123.4	2,475.6	5,571.2	13,815.3
Зөвлөмж	Өгсөн Биелсэн	2,344	1,934	2,384	2,521	2,480	9115	7873	8594	8331	8089	8188	10101	9656	81,610
Төсөвт оруулсан мөнгө	Тэрбум. төг	3.8	2.3	4.9	1.3	2.5	4.1	7.4	18.3	25.7	32.5	24.8	14.0	30.0	171.6
Үр өгөөж	Тэрбум. төг	2.7	3.4	1.2	1.6	6.5	21.7	34.3	103.7	148.8	255.4	392.5	812.4	540.9	2,325.1
Төсвийн орлого нэмэх санал	Тэрбум. төг	11.2	53.7	33.6	104.5	133.9	34.2	23.2	44.8	45.2	46.5	45.4	19.0	28.9	624.1
Үнээс: хэрэгжсэн	Тэрбум. төг	2.6	17.0	26.0	35.8	92.3	33.9	19.0	38.1	10.7	34.1	28.4	13.8	17.6	369.3
Үр ашиг дээшүүлэх	Тэрбум. төг	9.4	12.1	32.2	14.0	81.9	159.0	30.0	9.0	34.0	76.3	113.3	550.7	645.4	1,767.3
Үнээс: хэрэгжсэн	Тэрбум. төг	1.7	4.2	13.4	1.0	70.6	33.2	24.2	0.9	2.4	4.3	75.1	540.7	205.6	977.3

Тайлбар: 2003-2007 зөвлөмж гүйцэтгэлийн аудитын тоо /давхардсан тоогоор/
Гүйцэтгэлийн болон нийцлийн аудитын тоо



Хавсралт № 2

2015 оны Аймаг, нийслэлийн ИТХ-ын хүсэлтээр хийсэн аудитын судалгаа

№	Аймгийн нэр	№	Хийсэн аудитын нэр
1	Баянхонгор аймаг	1	Эмийн сангүүд ЭМД-ын сангаас үнийн хөнгөлөлт олгох зайлшгүй шаардлагатай эмээр үйлчлэх журмын мөрдөлт
		2	Хөдөлмөр эрхлэлтийн сангаас хэрэгжүүлж буй Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрийн үр дүн
		3	Бага орлоготой өрхийн гишүүдэд хүнсний талон олгох, хүнсний бүтээгдэхүүн худалдан авах, төлбөр тооцоо хийх, хяналт тавих үйл ажиллагааны зохицуулалт
2	Говь-Алтай аймаг	4	Сургууль, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн хүнсний материалын худалдан авалт, зарцуулалт, нөөцийн бүрдүүлэлт, татварын болон татварын бус орлогын төлөвлөлт, бүрдүүлэлт, үр нөлөөт байдал
3	Говьсүмбэр аймаг 5	5	Тээвэр, автозамын 2009-2014 он, 2015 оны эхний улирлын үйл ажиллагааны үр дүн
		6	Автозамын сангийн хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн
		7	Нэгдсэн эмнэлгийн 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа
		8	Сүмбэр сумын ЕБ-ын сургуулийн 5-р сургуулийн 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа
		9	Ус-Ду ОНӨҮГ-ын 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа
4	Дорноговь аймаг	10	Замын сангийн 2014 оны үйл ажиллагаа, үр дүн
		11	Сумын төвийн шинэчлэлийн хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн зарим хөрөнгө оруулалт
		12	Замын-Үүд сумын 700 хүний суудалтай соёл, спортын цагцолборын баоилга угсралтын ажил
5	Завхан аймаг	13	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын 2014-2015 оны үйл ажиллагааны үр дүн
6	Өвөрхангай аймаг	14	Халамжийн сангийн 2014 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн үр дүн
		15	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2014 оны хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн үр дүн
7	Өмнөговь аймаг	16	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
		17	ОНХС, төсвийн хөрөнгөөр хийгдсэн, худалдан авсан хөрөнгийн бүртгэл
		18	Орон нутгийн төсвийн гүйцэтгэл, Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн хоорондын уялдаа
8	Сүхбаатар аймаг	19	Сүхбаатар нийтлэг үйлчилгээ ОНӨААТҮГ-ын үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүн
		20	Цайртминерал ХХК-ийн 2014 оны улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн татварын орлогын бүрдүүлэлт, тайлагнал, үндсэн үйл ажиллагааны үр дүн
		21	УС ДУЛААН ОНӨААТҮГ-ын 2014 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр нөлөөт байдал
9	Ховд аймаг	22	Соёл спорт аялал жуучлалын газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		23	Байгаль орчин аялал жуучлалын газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		24	Буянт сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		25	Манхан сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

		26	Зэрэг сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		27	Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		28	6 дугаар тойргийн Тахарын албаны 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		29	Цагдаагийн газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		30	Аймгийн Прокурорын газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		31	Хөгжимт драмын театрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		32	Бүсийн оношлогоо эмчилгээний төвийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		33	Мөнххайрхан сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		34	Чандмань сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		35	Үйлдвэр хөдөө аж ахуйн газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		36	Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		37	Жаргалант сумын 2 дугаар сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		38	Жаргалант сумын 3 дугаар сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		39	Жаргалант сумын Цаст Алтай цогцолбор сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		40	Жаргалант сумын Прогресс сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		41	Жаргалант сумын 6 дугаар сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		42	Жаргалант сумын 7 дугаар сургуулийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		43	Боловсролын газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		44	Алтай сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		45	Үенч сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		46	Булган сумын төсөвт байгууллагуудын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		47	Булган дахь сум дундын 26 дугаар шүүхийн 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		48	Булган дахь Прокурорын газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
		49	Ус цаг уур орчин шинжилгээний газрын 2014 оны үйл ажиллагааны үр дүн
10	Хөвсгөл аймаг	50	Мөрөн сумын инженерийн шугам сүлжээтэй газруудад олгосон газар олголтын байдал
		51	Хөвсгөл аймагт хэрэгжиж буй Монгол мал хөтөлбөрийн хэргжилт, үр дүн
11	Хэнтий аймаг	52	Хэнтий-Ус ХХК-ийн 2014 оны санхүүгийн зарим үйл ажиллагаа



**Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагаанд
хийсэн системчилсэн үнэлгээний тайлан**

2016 оны 3 дугаар сарын 25

Улаанбаатар хот

Нэг. Ерөнхий зүйл

Улсын Их Хурлын Төрийн байгуулалтын байнгын хорооны 2013 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Байгууллагын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх аргачлал”-ыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/07 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайландаа туссан байгууллагын чиг үүрэг, хүний нөөцийн хэрэгцээ, төсвийн зарцуулалтад системчилсэн үнэлгээ хийж дүгнэлт гаргалаа.

Үнэлгээ хийхдээ холбогдох баримт материалыг судлах, байгууллагын ажилтнуудаас асуулгын хуудсаар санал асуулга авч нэгтгэн дүн шинжилгээ хийх зэрэг системчилсэн үнэлгээний арга зүйг ашигласан болно.

Үнэлгээний явцад Үндэсний аудитын газрын 2013-2018 онд хэрэгжүүлэх “Стратегийн төлөвлөгөө”-ний биелэлттэй танилцаж хэрэгжилтийн талаар тайланд тусгав.

**Хоёр. Байгууллагын чиг үүргийн
хэрэгжилтэд хийсэн үнэлгээний талаар:**

Төрийн аудитын байгууллагын сүүлийн 3 жилд дэвшүүлсэн бодлогын зорилт, тэдгээрийн хэрэгжилт

Төрийн аудитын байгууллагын 2007-2011 он хүртэл хэрэгжүүлэх Стратеги төлөвлөгөөний хугацаа дуусч, 2012 оноос стратегийн шинэ зорилтууд дэвшүүлэн ажиллах хэрэгцээ шаардлага бий болсон тул төрийн аудитын байгууллагын хэтийн төлөв, бодит хэрэгцээ, шаардлагыг судлан тодорхойлсны үндсэн дээр 2013-2018 онд хэрэгжүүлэх “Стратегийн төлөвлөгөө”-г боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудитороор батлуулан хэрэгжүүлж байна.

Төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг бэхжүүлэх, хууль эрх зүйн орчныг төгөлдөржүүлэх зорилгоор Төрийн аудитын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан УИХ-аар батлуулснаар төрийн аудитын байгууллагын үйл ажиллагаа, зохион байгуулалт, төсөв, санхүүгийн хувьд нэгдсэн тогтолцоогоор ажиллах эрх зүйн орчин бүрдэж, УИХ хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд үндэсний болон орон нутгийн түвшинд бүрэн дэмжлэг үзүүлж байна.

Төрийн аудитын үйл ажиллагаанд орчин үеийн мэдээллийн технологийг нэвтрүүлэхэд чиглэсэн дэд бүтэц бий болгох, программ хангамжийг боловсруулах, аудитын олон улсын стандартыг эх хэлнээ орчуулж үндэсний стандартыг бий болгох зорилтыг дэвшүүлж амжилттай хэрэгжүүлжээ.

Үндэсний аудитын газар жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөөндөө Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан стратеги зорилтыг тусган хэрэгжүүлж ажилласнаар бодлогын зорилтын 90 хүртэл хувийг биелүүлсэн байна.

Цаашид төрийн аудитын байгууллагын стратеги төлөвлөгөөнд тусгагдсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас шалтгаалан шийдэгдээгүй байгаа төрийн аудитын байгууллагын ажилтнуудын албан тушаалын цалингийн сүлжээг батлуулах, төрийн



аудитын байгууллагын ажилтнуудын олон улсын сургалтын төв байгуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн өөрчлөлтөд төрийн аудитын байгууллагын хараат бус байдлыг тусгуулах зэрэг асуудлыг УИХ-аар шийдвэрлүүлэх шаардлага байна.

Төрийн аудитын байгууллагын 2015 онд дэвшүүлсэн зорилтын хэрэгжилтэд хийсэн үнэлгээний талаар:

Төрийн аудитын байгууллага 2015 онд аудитын хугацаа, санхүүгийн болон хүний нөөцийг бүрэн ашиглаж, Төрийн аудитын тухай хууль, УИХ-ын тогтоол, шийдвэрээр ногдуулсан аудитын чиг үүргээ амжилттай хэрэгжүүлсэн байна.

УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2014 оны 20 дугаар тогтоолоор баталсан төрийн аудитын байгууллагын хийж гүйцэтгэх аудитын сэдвийн тоо буурснаар аудитыг чанартай хийх нөхцөл нэмэгдсэний дээр аймаг, нийслэлийн Аудитын газрууд бие даан нийцлийн аудит хийж, дүнг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулах боломжтой болсон байна.

Төрийн аудитын байгууллага 2015 онд системийн хэмжээгээр гүйцэтгэлийн болон нийцлийн 9 аудитыг нэгдсэн удирдамжийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд 5 аудитын тайланг УИХ-ын Төсвийн байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлжээ. Энэ нь хууль тогтоох төрийн дээд байгууллага болох УИХ хяналтыг төрийн аудитын үйл ажиллагаатай уялдуулах, аудитын тайлангаар нийтийн сонсгол хийдэг парламентын хяналтыг төлөвшүүлэхэд чиглэсэн чухал алхам болсон байна.

Монгол Улсын Ерөнхий аудитор 2014 онд “Санхүүгийн тайлангийн аудитын журам”, 2015 онд “Санхүүгийн тайланд итгэл үзүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус батлан гаргаж, жил бүр хуулиар тодорхойлогдсон хугацаанд санхүүгийн зөрчил, дутагдалгүй ажилладаг зарим байгууллагын санхүүгийн тайланд итгэл үзүүлэх, санхүүгийн тайланг түүврийн аргаар аудитад хамруулдаг болсон нь нэг аудиторт ногдох ажлын ачаалалыг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитын үйл явц, үе шатны ажлыг цахим хэлбэрт шилжүүлэн гүйцэтгэлийг хянах, удирдах зэрэг санхүүгийн тайлангийн аудитын бүхий л үйл явцыг хамруулах боломжийг хангах зорилгоор СТАУС программыг санхүүгийн аудитад ашиглаж эхэлсэн байна.

Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын өгөгдлүүдийг цуглуулах “Checklist” программыг гүйцэтгэлийн аудитад нэвтрүүлснээр аудитын үйл ажиллагаанд мэдээллийн технологи ашиглах бодлого бодитойгоор хэрэгжиж эхэлсэн байна.

ҮАГ 2015 онд гүйцэтгэлийн аудитын үйл ажиллагаанд жил бүр хуулийн дагуу хийгддэг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн тесэл, арга хэмжээний аудитад зориулан нээлттэй эхийн модуль ашиглан 800 гаруй тесэл, арга хэмжээний цахим хувийн хэрэг бүхий мэдээллийн санг үүсгэсэн байна.

Төрийн аудитын байгууллага 214 /давхардсан тоогоор/ гүйцэтгэлийн аудит хийсний 62.2 хувь буюу 133 нь нэгдсэн төлөвлөгөөгөөр хийгдэж, нийт аудитын 40.1 хувь буюу 86 нь улс орны асуудлыг, 43.5 хувь буюу 93 нь орон нутгийн асуудлыг, 4.7 хувь буюу 10 нь салбарын асуудлыг, 11.7 хувь буюу 25 нь байгууллагын асуудлыг хамарсан байна.

Тайлант онд төрийн аудитын байгууллага 157 /давхардсан тоогоор/ нийцлийн аудит хийж аудитад 6.6 мянган байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийг хамруулж, нийт 691.8 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлсэн бөгөөд үүний 1.9 хувь буюу 13.1 тэрбум



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

төгрөгийн зөрчлийг Үндэсний аудитын газар, 98.1 хувь буюу 678.7 тэрбум төгрөгийн зөрчлийг аймаг, нийслэлийн Аудитын газар илрүүлсэн байна.

Үндэсний аудитын газрын үйл ажиллагаанд системчилсэн үнэлгээ хийх ажлын хүрээнд аймаг, нийслэлийн Аудитын газрын дарга, төрөлжсөн аудитын газрын ажилтнуудаас 9 асуудлаар санал, асуулга авсан дүнгээс үзэхэд төрийн аудитын байгууллага нэгдсэн удирдлагын шууд тогтолцоонд шилжснээр аудитын чанар, үр нөлөө дээшилж, байгууллагын үйл ажиллагаа сайжирсан гэж олонх нь дүгнэсэн байна.

Төрийн аудитын байгууллага чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомж, АОУС, НББОУС, журам зааврыг мөрдлөг болгон ажиллаж нийт 30.0 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт оруулж, санхүүжилтийн нэг төгрөгт ногдох үр өгөөж 56.66 төгрөгт хүргэсэн.

Дэлхийн банкнаас хөндлөнгийн аудитын цар хүрээ, шинж байдал, зөвлөмжийн мөрөөр тавьж буй хяналтын талаар үнэлгээ хийн “B+” үнэлгээ өгч төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааг “сайн” гэж үнэлсэн байна.

Гурав. Хүний нөөцөд хийсэн үнэлгээний талаар:

УИХ-ын Төсвийн байнгын хорооны тогтоолоор баталсан зохион байгуулалтын бүтэц, орон тооны дээд хязгаарын /389/ хүний нөөцтэй ажилласан байна.

Төрийн аудитын тухай хуулийн хүрээнд хүний нөөцийн нэгдсэн тогтолцоонд шилжсэнтэй холбогдуулан “Байгууллагын хүний нөөцийн бодлогын баримт бичиг”, “Хүний нөөцийн хөгжлийн болон хүний нөөцийн нийгмийн хамгааллын хөтөлбөр” зэргийг 2015 онд боловсруулан Монгол Улсын Ерөнхий аудитороор батлуулан мөрдөн ажилласан байна.

2015 онд нийт ажиллагсдын 73.5 хувь буюу 286 нь аймаг, нийслэлийн аудитын байгууллагад, 26.5 хувь буюу 103 нь Үндэсний аудитын газарт ажиллаж байгаагаас хүйсийн хувьд 73.0 хувь нь эмэгтэйчүүд эзэлж байгаа бөгөөд нийт ажиллагсдын 74.8 хувь нь нягтлан бодогч, эдийн засагчийн мэргэжилтэй байгаа бол 25.2 хувь нь инженер болон бусад төрлийн мэргэжилтнүүд байна.

Төрийн аудитын байгууллагад ажиллагсдыг насны бүлгээр авч үзвэл харьцангуй тэнцвэртэй байдал ажиглагдаж байгаа ба 30-аас доош насны ажилтнууд 24.6 хувийг эзэлж байна.

Төрийн аудитын байгууллагын ажилтнуудын залгамж чанар, тогтвортой байдал хангагдахуйц хэмжээний харьцаатай байна гэж үзэж болох ба цаашид энэ харьцааг хүний нөөцийн бодлогоор тогтвортой барих, залуу боловсон хүчнийг сургаж дадлагажуулах, мэдлэг, үр чадварыг дээшлүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Нийт ажилтнуудын онолын мэдлэг, ажлын туршлагыг авч үзвэл төрийн аудитын байгууллагын ажилтнуудын 35.2 хувь нь магистр түүнээс дээш зэрэг цолтой, 49.1 хувь нь мэргэшсэн нягтлан бодогч, нийт ажилтнуудын 23.3 хувь нь 10 болон түүнээс жил ажилласан байна.

Дурслэл 1.1





Дүрслэл 1.2



Аудитор, шинжээчдийг мэргэшлийн түвшингээр нь аттестатчлах, урамшуулах систем бий болгох зорилгоор төрийн аудитын байгууллагын ажилтны мэдлэг чадварыг дээшлүүлэх, мэдлэг чадварын түвшинг тогтоон шалгах зориулалттай 700 гаруй асуулт, бодлоготой тестиийн сан бүхий программыг нэвтрүүлжээ. Энэхүү программыг ашиглан төрийн аудитын байгууллагын ажилтнуудын мэргэшлийн түвшинг тогтоох шалгалтыг нэгдсэн байдлаар богино хугацаанд авч төрийн аудитын арга зүй, төрийн аудитын байгууллагын чадавхийг бэхжүүлэх, үр дүнг үнэлэх боломжоор хангагдсан байна.

Төрийн аудитын байгууллага 2015 онд ажиллагсдын ажлын байрыг засч тохижуулах, зарим шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангах арга хэмжээ авч ажилласан ч Үндэсний аудитын газрын оффисын өрөө тасалгаа хүрэлцэхгүй, зай талбай хэтэрхий бага, аудиторуудын ажиллах ажлын байрны нөхцөл хууль журамд заагдсан шаардлагад хүрээгүй байна.

Дөрөв. Төсвийн зарцуулалтад хийсэн үнэлгээний талаар:

Төсвийн Ерөнхийлөн захирагч төсвийг төлөвлөх, батлах, хуваарилах, захиран зарцуулахтай холбоотой төсвийн удирдлагын бүрэн эрхээ хэрэгжүүлэн ажиллажээ.

Хөтөлбөрт сууринласан бүтээгдэхүүнийг санхүүжүүлэх төсвийн төлөвлөлтийн арга зүйг баримтлан 2015 оны төсвийг "Аудитын өртөг тооцох аргачлал"-аар боловсруулж Монгол Улсын Ерөнхий Аудиторын төсвийн багцыг 10,0 тэрбум төгрөгөөр батлуулж, төсвийн тодотголоор 2015 оны төсвийг 0,3 тэрбуунаар бууруулж 9,7 тэрбум төгрөгөөр баталсан бөгөөд 9,5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан байна.

2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчаас эрх шилжүүлсний дагуу төсвийн төвлөрүүлэн захирагч ЯАГ болон аймаг, нийслэлийн аудитын газруудын төсвийн шууд захирагчийн аудитын үйлчилгээний зардалд нийт 1,1 тэрбум төгрөгийн төсвийн санхүүжилт хийснээр аудитын үйл ажиллагаа хэвийн явагдах нөхцөлийг бүрдүүлжээ.

Мөн төсвийн шууд захирагчдаас төсвийн холбогдох мэдээ, тайланг тухай бүр авч нэгтгээд тогтоосон хугацаанд Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захирагааны төв байгууллагад хүргүүлэн төсвийн өр, авлага үүсгэхгүй байхаар холбогдох зохицуулалтуудыг хийж хяналт тавин төсвийн сахилга батыг ханган ажилласны дунд УИХ-ын даргын захирамжаар томилсон "Мэдээлэл аудит" ХХК-иар аудит хийлгэхэд нийт Төсвийн шууд захирагч нар зөрчилгүй гэсэн дүгнэлттэй гарсан бөгөөд 6 аймгийн тайланд өртгөө нөхсөн үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, авлага барагдуулах, санхүүгийн программыг сайжруулах зөвлөмж өгсөн байна.



20.16 он 2 сар 24-

“МЭДЭЭЛЭЛ - АУДИТ” ХХК
НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ХЯМДЫН ИТГЭЛЭЛГЭСЭН БАЙГУУЛАГА

№

УБ хот. БГД 17- хороо
Амнаасонцагийн гудамж,
“МБО” чад. №06 тоот
УЧБС: 978-11-388611
С.тэл: Модончижидээ@yandex.ru

**ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР, ТАМГЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ Л.ДУЛМАА танаа**

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Төрийн аудитын тухай хуулийн 15.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу “Үндэсний аудитын газар”-ын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мешген гүйлгээ, омчийн борчлолт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланда аудит хийв.

“Үндэсний аудитын газар”-ын удирдлагын нь Төсвийн тухай хуулийн 26.1, 54.3-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үзэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Нягтлан бодогчдын олон улсын холбоосоос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг бидизэс шаарддаг.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчилэл тодруултыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийснэг чухал тооцоолыг үзэлж цэгнэ, санхүүгийн тайлангийн сренхий толилуултыг үзэлдэг.

Бидний хийснэг аудит санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохицтой үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.



Зорчилгүй санал дүгнэлт

“Үндэсний аудитын газар”-ын 2015 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон төсвийн гүйцэтгэлийн тайлант Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.



ЗАХИРАЛ, АУДИТОР

— Д.ТОВУУДОРЖ



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайллан



Үзүүлэлт: Төслийн Аудитын Газар
Тайллан он: 2015-12-31 байдлаарх

АУДИТ ХИЙГДСЭН САНХУУГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

тогтолцоо

ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн зөрөгө		
Монго. түүхтэй адилтгах хөрөгө	12,025.73	
Кассанд бий авсан мөнгө		
Банкнад байсан болжи мөнгө /%	12,028.73	
Авлага	1,300,100.00	8,192.31
Ажиллагчдтай холбогдсон		
Төлбөрт уйлчилгээний зөвлө		
Тийлас, санхүүжилт		
Бусад авлагы	1,300,100.00	8,192.31
Барал магеризл	298,501,520.00	303,684,163.53
Бичиг хүргийн материал	5,479,479.99	20,344,959.99
Аж ахуйн материал	21,107,940.01	19,624,339.40
Санбэг хэрэгсэл		
Түүнч цахих тослол материал		1,730.14
Бусад хантамжийн материал		2,234,720.00
Бусад	271,914,100.00	261,478,394.00
Эргэлтийн хөрөнгийн дүн	299,813,648.73	303,692,355.84
Эргэлтийн бус хөрөнгө		
Үзлээн хөрөнгө	686,120,761.47	643,128,226.88
Авто тэмврийн хувогодл	115,107,013.00	115,107,013.00
Хуримтлагдсан зөлгээ	(88,473,753.30)	(92,024,854.62)
Миншиг, тоног төхөөрөмж	821,858,379.65	619,197,343.87
Хуримтлагдсан зөлгээ	(368,545,088.21)	(248,119,207.72)
Тавьшиг, алхуйн эд хөтөлж	207,393,455.90	165,942,225.80
Хуримтлагдсан зөлгээ	(137,925,367.42)	(44,979,046.70)
Бусад үзлэсэн хөрөнгө	36,880,834.00	36,880,834.00
Хуримтлагдсан зөлгээ	(2,175,342.15)	(10,876,710.75)
Номын фонд	2,000,630.00	2,000,630.00
Дуусагчай, барилга байгууламж	100,000,000.00	100,000,000.00
Биет бус хөрөнгө	278,974,260.97	243,103,856.85
Программ хантамж	279,713,864.30	280,098,864.30
Хасалдуулга	(8,739,603.33)	(24,995,007.45)
Бусад биет бус хөрөнгө		
Хасалдуулга		
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	957,895,822.44	898,232,883.73
ИИХТ ХӨРӨНГИЙН ДҮН	1,256,908,671.17	1,201,924,439.57
ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН		
Ор төлбөр		
Богино хутамжийн ор төлбөр		
Оглог		
Ажиллагчдтай холбогдсон оглог		
Тийлас самхүүжилтийн оглог	1,300,100.00	
Богино хутамжийн ор төлбөрийн дүн	1,300,100.00	0.00
Ор төлбөрийн эхийн дүн	1,300,100.00	0.00
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн		
Засгийн газрын оруулсан хийнчил	553,236,574.16	553,236,574.16
Омных үсийн үр дүн	511,736,283.96	511,736,283.96
Тайлант үсийн үр дүн		(53,684,131.60)
Дикси илээгээний заруу	190,635,713.05	190,635,713.05
Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	1,255,608,571.17	1,201,924,439.57
ОР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	1,256,908,671.17	1,201,924,439.57

Тайллан гаргасан: Шанисон

Абжийн цэргээ

Ц.Отгонжаргал

Хийсан: Захаров, МНВ

Д.Тоотуулжарх



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан

АУДИТ ХИЙГДСН САНХҮҮТИЙН ҮР ДУВГИЙН ТАЙЛАН

Тайланы огноо: 2015-12-31 байгууллагын

Годигчийн

ҮЗҮҮЛЭМТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСНИЙ ҮЛДЭГДЭЛ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО		
Үргэлж санхүүжилт	2,504,246,300.00	3,104,457,607.69
Хөрөнгийн санхүүжилт	1,020,760,693.00	60,418,200.00
Дэл шатны төслийн захиргаас		282,526,608.00
Хүүгийн орложо	12,028.73	8,192.31
Үндслэлийн ажиллагчны орложо	109,545,620.00	298,907,314.62
Үндслэлийн бус уйх ажиллагчны орложо	1,300,100.00	7,285,000.00
Үюн төмөрцүү хүчин авсан орложо		
Татварын орложо		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,635,864,741.73	3,753,602,922.62
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ		
Палли хөлс бөхийн измэдэлдэд урамшилт	1,571,992,891.04	1,978,771,250.00
Нийтийн хамгаалалын хийнгээл	164,851,479.64	214,500,447.00
Хангамж, барын материалын зардал	58,239,770.00	125,117,226.20
Нормативт зардаа		49,000.00
Эд хогнис, ургалж засчарын зардаа	7,163,570.00	238,207,380.00
Томилолт, зочмын зардаа	39,875,399.99	307,321,562.00
Бусдамр гүйцэтгүүдэсийн кийл, үйчинчлэний хурамж		426,511,500.00
Барын үйчинчлээний бусад зардаа	315,592,379.23	151,259,900.71
Татвар төвлөрүүдэлт		94,941,998.31
Үргэлж шилжүүлж	637,237,257.38	270,606,790.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,844,952,747.28	3,807,287,054.22
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	790,911,994.45	(53,684,131.60)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
Үндслэлийн худалдсаны гарз		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЙН ҮР ДҮН	790,911,994.45	(53,684,131.60)

Тайлан гарсан: Шарасан

Очижин ширгэлт

Ц.Онцогжаргал

Ханасын: Захирах, МШБ

Д.Төгөлзүүлж

Очижиг



ОМЧИЙН ООРЧЮЛТИЙН НЭСТГЭСЭН ТАЙЛАН

Галчлухынч: Енээсний Аудитын Газар

Тайлант он: 2015-12-31 байгальдарх

тогтолцоо/

	ҮЗҮҮЛЭЛТ	ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭДГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ХУРИМТЛАГДСАН ҮРДҮН	НИЙТ ДҮН
1	2014 оны 12-р сарын 31-ийн үзүүлэлт	553,236,574.16	190,635,713.05	511,736,283.96	1,255,608,571.17
2	Нийтлан бодох бүргэдийн бодлогын борчолтийн нэгж, алдааны залруулга				
3	Залруулсан үзүүлэлт	553,236,574.16	190,635,713.05	511,736,283.96	1,255,608,571.17
4	Тайлант усийн цэвэр эшиг (алдаан)			(53,684,131.60)	(53,684,131.60)
5	Үндсэн хөрөнгийн осолт бууралт				-
6	Дахин үзүүлжийн измээдлийн хэрэгжсээ дүн				-
7	2015 оны 12-р сарын 31-ийн үзүүлэлт	553,236,574.16	190,635,713.05	458,052,152.36	1,201,924,439.57

Тайлант гаргасан: Шинжүүч *Д.Олонцагал*

Хавасан: Зэхирэл, МШБ *Л.Товуудорж*



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан



Гэлчлүүдэдч: Тийнээний Аудитын Газар

Тайлан ог: 2015-12-31 Байгальтэрүү

МОНГОЛ ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ОХНИЙ ҮДЛЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮДЛЭГДЭЛ
Ургал санхүүжилт	2,504,246,300.00	3,104,457,607.69
Хороний санхүүжилт	1,020,760,693.00	60,418,200.00
Дээд шатны тоснийн захирагчалс		282,526,608.00
Нийгмийн давтальбын сангас	12,010,761.00	40,944,015.00
Хуутийн орлогото	12,028.73	
Үндсэн үйл ажиллагчны орлогото	109,545,620.00	298,907,314.62
Үндсэн бүс үйл ажиллагчны орлогото	1,300,100.00	8,192.31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНГОЛ ОРЛОГЫН ДУН	3,647,875,502.73	3,787,261,937.62
Цагдаа хөх болон измэдэлаа урамшина	1,584,289,032.72	1,978,771,250.00
Нийгмийн хамгийн шийдвэртэй	164,851,479.64	214,500,447.00
Хангамж, барсаа материалын зардал	58,761,200.00	117,338,761.00
Нормативын зардал		49,000.00
Эд хошига, ургал засварын зардал	7,583,570.00	233,580,480.00
Томилогт, хочина зардал	89,875,399.99	311,573,862.00
Бусдадаа гүйлгүүжүүсийн ажил, үйлийнгээний кураалж		426,511,500.00
Барсаа үйлийнгээний бусад зардал	222,903,802.27	38,017,442.00
Таган тохиолдруулж		94,941,998.31
Ургал шилжүүрүүд	637,237,257	311,558,997
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНГОЛ ЗАРДЛЫН ДУН	2,765,601,742.00	3,726,855,766.35
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МОНГОЛ ГҮЙЛГЭЭ	882,273,760.73	60,406,171.27
Бист ба бист бус зарчмын хувьдадаа авсан зардал	1,020,760,693.00	60,418,200.00
Хоронийн бусад зардал		
ХӨРӨНГО ОРУУЛАЛТЫН ИЭВЭР МОНГОЛ ГҮЙЛГЭЭ	(1,020,760,693.00)	(60,418,200.00)
САЛХҮҮТИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МОНГОЛ ГҮЙЛГЭЭ		
НИЙТ ЦЭВЭР МОНГОЛ ГҮЙЛГЭЭ	(138,436,932.27)	(12,028.73)
Мөнгө түүрэй адилтых хоронийн эхийн үзүүлэлт	138,498,961.00	12,028.73
Мөнгө түүрэй адилтых хоронийн эхийн үзүүлэлт	12,028.73	0.00

Тайлан гарчсан: Шинээний Аудитын Газар
Хийсдэг: Заянбаатар, Монгол Улс

Н.Онгонжаргал

Д.Төмөнхийжик



Төрийн аудитын байгууллагын 2015 оны үйл ажиллагааны тайлан



Үзүүлэлт: Ундэсний Аудитын Газар
Тайлант он: 2015-12-31 байдлаарх

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгийр/

ҮЗҮҮЛЭЛТ	ТОЛОВЛОГОӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ЗӨРҮҮ
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭРЭР ЗЭЭЛИЙН ДУН			
НИЙТ ЗАРЛАГЫН ДУН			
УРСГАЛ ЗАРДЫН ДУН	3 462 032 874,00	3 447 402 415,69	14 630 458,31
Барыг, үйлчилгээний зардал	3 362 283 465,00	3 280 760 942,00	21 522 523,00
Цалин холс болон шомжидын урамшил	1 978 771 250,00	1 978 771 250,00	0,00
Ажил олонгчоос нийтийн дагтадаа төхөн инимгэл	217 727 514,00	214 500 447,00	3 227 067,00
Барыг, үйлчилгээний бусад зардал	1 105 784 701,00	1 087 489 245,00	18 295 456,00
Бичиг хэрэг	23 358 000,00	26 238 572,00	-2 880 572,00
Тээвэр /шатахуу/	61 082 067,00	58 519 052,00	2 563 015,00
Шинэдлийн холбог	30 329 800,00	28 554 262,00	1 775 538,00
Дотоод албан томилогт	84 155 084,00	60 556 388,00	23 598 696,00
Галанд албан томилогт	75 239 500,00	75 114 861,00	124 639,00
Зочин төмөнгэг хүлээн авах зардал	69 161 400,00	75 902 693,00	-6 741 293,00
Ном хэвлэх шах	1 434 700,00	489 300,00	945 400,00
Багас узүүлэлт, түргийн мэдэх, аж ахуйн за зүйлс	1 137 100,00	3 537 575,00	-2 400 475,00
Ургал эсвэр	232 287 400,00	228 727 300,00	3 560 100,00
Тавилга, эд хөгжил	60 500 000,00	60 804 200,00	-304 200,00
Багасгүй техникик хэрэгслэл	147 000,00	4 467 100,00	-4 320 100,00
Нормийн хувцас зөвлөн залалт	140 900,00	49 000,00	91 900,00
Бусдаар гүйцэтгүүсэн ажлыг, Үйлчилгээний төлбөр, хураамж	386 479 250,00	382 479 250,00	4 000 000,00
Даалгавын үйлчилгээ	2 008 700,00	2 008 650,00	50,00
Тээврийн хөргөлтийн татвар	251 600,00	251 600,00	0,00
Тээврийн хөргөлтийн сийненхүү	36 000,00	22 000,00	14 000,00
Мэдрэлшийн технологийн зардал	21 700 000,00	21 700 000,00	0,00
Гармын төлбөр	20 050 000,00	20 050 000,00	0,00
Бискийн тамир уралдаан тэмцээн	4 174 500,00	4 174 500,00	0,00
Хичээл, үйдвөргүйлийн дадлага	32 111 700,00	33 842 942,00	-1 731 242,00
Төвлөрүүлэх шалгаруулж		12 827 264,69	-12 827 264,69
Татас, ургал шалгаруулж	159 749 409,00	153 814 209,00	5 935 200,00
Засгийн газрын гадаад шийдвүүлэг	2 217 300,00	2 217 300,00	
Ажил олонгчоос олонх тэргэмж, урамшуулалт	14 240 000,00	9 720 000,00	4 520 000,00
Тэлтэвэрт гарахад нь олонх нэг удангийн монгол тэлэмж	21 997 551,00	21 997 551,00	
Нэг удангийн тэлэмж, урамшуулалт	121 294 558,00	119 879 358,00	1 415 200,00
ЗАРДЫН ГАНХУУЖУУЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3 462 032 874,00	3 447 402 415,69	14 630 458,31
Төслийн санхүүжүүлэх	3 462 032 874,00	3 164 875 807,69	297 157 066,31
Нэмээж санхүүжүүлэх		282 526 608,00	-282 526 608,00
Монгол хөрөнгийн эхийн удзэгээл		0,00	0,00
Монгол хөрөнгийн эхийн удзэгээл		0,00	0,00
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1	0,00
АЖИЛЛАГСАД БҮТД	104	104	0,00
Удирдах ажилтан	3	3	0,00
Гүйцэтгэх ажилтан	101	101	0,00
Үйлчилж ажилтан		-	
Гэрээг ажилтан		-	

Тайлсан гарчмын Шинжүүч

Дэшилжүүлж сан - Ц.Огтоонжаргал

Хийсгэд: Захирал, МНБ

Д.Төвүүдорж

Л.Очиржаргал